



SNC • LAVALIN

Монгол: Чойр-Сайншандын Цахилгаан дамжуулах агаарын шугам барих төсөл

Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын
үнэлгээ (БОННБҮ) Техникийн бус хураангуй
(ТБХ)

2021 оны 6-р сар

Санамж

Энэхүү баримт бичиг болон үүний агуулгыг зөвхөн ЕСБХБ болон Чойр-Сайншандын хооронд тавигдах Цахилгаан дамжуулах агаарын шугамын Төсөлд ашиглах зорилгоор бэлтгэсэн болно.

SNC-Lavalin нь энэхүү баримт бичиг ба/эсхүл үүний агуулгаас үүдэлтэй эсхүл холбоотойгоор бусад талуудын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Энэхүү баримт бичиг нь нүүр хуудсыг оруулан 28 хуудсаас бүрдэнэ.

Баримт бичгийн түүх

Хяналт	Тайлбар	Боловсруулсан	Шалгасан	Хянасан	Зөвшөөрсөн	Огноо
Хув 1.0	Баримт бичгийн төсөл	AR	СК	КР	GJ	24/07/2020
Хув 2.0	Олгосон	AR	СК	КР	GJ	20/10/2020
Хув 3.0	ЕБСБХБ-ны саналын дагуу шинэчилсэн	AR	СК	КР	GJ	24/11/2020
Хув 4.0	Трассын шугам шинэчлэгдсэний дараа засварласан	СК	СК	КР	GJ	15/06/2021

Зээлдүүлэгчийн гарын үсэг

Зээлдүүлэгч	ЕСБХБ
Төсөл	Чойр-Сайншандын цахилгаан дамжуулах агаарын шугам
Ажлын код	5196941

Агуулга

Бүлэг	Хуудас
1. Танилцуулга	5
1.1. Оршил	5
1.2. Техникийн бус хураангуйн зорилго	6
1.3. Техникийн бус хураангуйн хамрах хүрээ	6
2. Төслийн тодорхойлолт	6
2.1. Төслийн тойм	6
2.2. Төслийн хэрэгцээ шаардлага	6
2.3. Төслийн онцлог	7
2.4. Төслийн хувилбар	8
3. Хууль эрх зүйн орчин, нийцэл	10
3.1. Үндэсний шаардлагууд	10
3.2. ЕСБХБ-ны шаардлагууд	10
4. Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл ба бууруулах арга хэмжээний хураангуй	11
4.1. Танилцуулга	11
4.2. Барилгын үе шат	11
4.3. Ашиглалтын үе шат	20
4.4. Үлдэх нөлөөллийн үнэлгээ	24
5. Оролцогч талуудын оролцоог хангах ба Гомдол шийдвэрлэх механизм	25
5.1. Оролцогч талуудын оролцоо	25
5.2. Гомдол шийдвэрлэх механизм	26
6. Байгаль орчин, нийгмийн менежмент	27
6.1. Төслийн менежмент, гүйцэтгэл	27
6.2. Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө	27
6.3. БОНУТ болон Менежментийн төлөвлөгөө	27
6.4. Түр талбайд тавигдах шаардлагууд	27
6.5. Талбайг хүлээлгэн өгөх	28

Зураг

Зураг 1-1. Төслийн байршил	5
Зураг 2-1. Цахилгаан дамжуулах агаарын шугам	7
Зураг 4-1. Төслийн бүс дэхь улсын тусгай хамгаалалттай газрын байршил	12
Зураг 4-2. Төслийн бүс дэхь орон нутгийн тусгай хамгаалалттай газрын байршил	12

Товчилсон үгийн жагсаалт

Товчилсон үг	Тайлбар
ЕБСХБ	Европын сэргээн босголт, хөгжлийн банк
БОНУ	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ
БОННУ	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
ЦСО	Цахилгаан соронзон орон
БОНУАТ	Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө
БОННБУ	Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ
БОНМХШТ	Байгаль орчин, нийгмийн менежмент, хяналт шинжилгээний төлөвлөгөө
ОУБХН	Олон улсын байгаль хамгаалах нийгэмлэг
кВ	Киловольт
ГЧНШУА	Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа
МУҮС	Монгол улсын үндэсний стандарт
ЦДҮС	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ
ТБХ	Техникийн бус хураангуй
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ОТОХТ	Оролцогч талуудын оролцоог хангах төлөвлөгөө


1. Танилцуулга

1.1. Оршил

Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ) Чойр-Сайншандын хооронд 220 киловольт (кВ)-ын 2 хэлхээт 220 километр (км) цахилгаан дамжуулах агаарын шугам (ЦДАШ) тавих, 220/110/35 кВ-ын шинэ дэд станцыг Сайншандад барих болон Чойрын 220 кВ-ын дэд станцыг өргөтгөх ажлыг (цаашид Төсөл гэх) санхүүжүүлэх зээлийг Монгол улсын Засгийн Газарт олгох асуудлыг хэлэлцэж байна.

Эрчим Хүчний Яам (ЭХЯ) нь Төслийн Зээлдэгч байна. Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ Төрийн Өмчит Хувьцаат Компани (Компани эсхүл ТӨХК) нь Төсөл Хэрэгжүүлэгч бөгөөд ашиглагч байна.

Төслийн байршлыг Зураг 1-1-д харуулав. Төсөл Говь-Сүмбэр аймгийн төв Чойр хотод байрлах дэд станцаас эхэлнэ. ЦДАШ энэхүү дэд станцаас зүүн өмнө зүгт үргэлжилж Дорноговь аймгийн төв Сайншанд хот дахь дэд станцаас ойролцоогоор 2.5 км зайд шинээр баригдах дэд станц хүрнэ.



Зураг 1-1. Төслийн байршил

ЕСБХБ нь 2014 оны Байгаль Орчин ба Нийгмийн Бодлоготой (БОНБ) холбоотойгоор Төслийг “А” ангилалд багтаасан бөгөөд энэ нь Оролцогч Талуудын Оролцоог Хангах Төлөвлөгөө (ОТОХТ) бүхий Байгаль Орчин, Нийгэмд Нөлөөлөх Байдлын Үнэлгээг (БОННБҮ) боловсруулах шаардлагатай гэсэн үг юм.

ЕСБХБ нь Дабльу Эс Аткинз Интернэйшнл (Аткинз) болон дэд гэрээлэгч Састайнабилити Ийст Эйжия ХХК (СИЭ), Монгол улсын Хараат бус судалгааны хүрээлэн (МУХБСХ) болон Эко Трэйд ХХК-тай хамтран ЕСБХБ-ны шаардлагуудад нийцүүлэн БОННБҮ-г боловсруулж, БОННБҮ Толилуулгын Багц Материалыг бэлдэх ажлыг даалгасан. Энэхүү Техникийн бус хураангуй (ТБХ) нь БОННБҮ Толилуулгын Багц материал доторх дараах баримт бичгүүдийн нэг юм:

- БОННБҮ-ний тайлан;
- Оролцогч талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ОТОХТ);
- Байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах, менемжентийн төлөвлөгөө (БОННБМТ);
- Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа (ГЧНШҮА); ба
- Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө (БОНҮАТ).

1.2. Техникийн бус хураангуйн зорилго

Энэхүү ТБХ-н зорилго нь дээр дурдсан БОННБУ-ын тодруулгын багц баримт бичигт агуулагдаж буй мэдээллийг хялбар, ойлгомжтой байдлаар хураангуйлан хүргэх явдал юм. Төслийн талаарх мэдээллээр хангах, түүнчлэн БОННБУ-ийн үр дүн, байгаль орчин, нийгмийн эерэг болон сөрөг нөлөөллийн менежментийн арга хэмжээ, оролцогч талуудын оролцооны явц, гомдол шийдвэрлэх механизмын талаарх мэдээллийг хүргэх зорилгоор боловсруулсан болно.

1.3. Техникийн бус хураангуйн хамрах хүрээ

ТБХ-д дараах зүйлийг тодорхойлно:

- Төсөл болон хувилбарууд;
- Барилга, ашиглалтын явцад Төсөлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн нөлөөллийн хураангуй;
- Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, хяналтын шаардлага;
- Менежментийн арга хэмжээний хураангуй; ба
- Оролцогч талуудын оролцоог хангах төлөвлөгөө, гомдол шийдвэрлэх механизмын тойм.

2. Төслийн тодорхойлолт

2.1. Төслийн тойм

Энэхүү Төсөл нь Эрчим Хүчний Яамны өндөр ач холбогдолтой төсөл гэж тодорхойлогдсон. Эрчим хүчний яамны боловсруулсан 2013 оны Техник Эдийн засгийн Үндэслэлд Чойр-Сайншанд-Замын-үүдийн хооронд цахилгаан түгээх шугам, шаардлагатай дэд станцууд зэрэг цахилгаан түгээх шугам барих төслийг өргөн хүрээнд авч үзсэн. ТЭЗҮ-ийн техникийн хяналтыг Меркадос - Ариэс олон улсын байгууллагаас 2020 онд хийсэн. Цахилгаан дамжуулах энэхүү урт шугамыг барих төсөл нь Монгол улсын эрчим хүчний салбарын үр дүн, аюулгүй байдал, байгаль орчны хамгаалалтыг сайжруулахад чиглэсэн стратегийн зорилтыг тусгасан 2015-2030 оны Эрчим хүчний тухай батлагдсан бодлогыг хэрэгжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулах юм.

2.2. Төслийн хэрэгцээ шаардлага

Монгол улсын цахилгаан дамжуулах, түгээх дэд бүтэц нь хуучирсан, цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээ ихээхэн алдагдалтай, үр ашиггүй, найдваргүй байгаа бөгөөд яаралтай нөхөн сэргээж, шинэчлэн, сайжруулах шаардлагатай байна. Ихэнх цахилгаан үйлдвэрлэх, дамжуулах байгууламжууд нь 1960-1980 оны хооронд баригдсан бөгөөд хуучирсан технологиор ажиллаж байна.


Монгол улсын Эрчим хүчний яамны 2019 оны мэдээлснээр, цахилгаан дамжуулалт, түгээлтийн алдагдал 13 орчим хувь байгаа нь олон улсын сайн туршлага болох 5%-иас ихээхэн зөрүүтэй байна. Тийм учраас Монгол улсын засгийн газрын хувьд, бусад салбаруудын хөгжлийг хангах, сэргээгдэх эрчим хүч (салхи, нарны эрчим хүч гэх зэрэг) -ний эх үүсвэрээс цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, дэмжихийн тулд найдвартай цахилгаан эрчим хүч нийлүүлэх, дамжуулах сүлжээг бий болгох нь нэн чухал асуудал болсон.

Дорноговь, Говьсүмбэр аймгийн ЦДАШ-ын цахилгаан дамжуулах ачааллын эрэлт хэрэгцээ жилээс жилд өсөн нэмэгдсээр байгаа тул тус төслийг хэрэгжүүлэх шаардлага тулгараад байна. Мөн түүнчлэн Замын Үүдийн чөлөөт эдийн засгийн бүс болон Төслийн бүсэд хийгдэх бусад бүтээн байгуулалтын ажлууд одоогийн ЦДАШ-ын хүчин чадлаас давсан эрчим хүчний хэрэгцээг эрс нэмэгдүүлнэ гэж үзэж байна; иймээс ЦДАШ-ын дэд бүтцийн ажлыг эхлүүлэх зүй ёсны шаардлага бий болсныг дурдах нь зүйтэй.

2.3. Төслийн онцлог

2.3.1. Төслийн маршрут

Төслийн байршлыг Зураг 2-1-д харуулав. Төсөл нь Говьсүмбэр *аймгийн* төв Чойр хотын хуучин дэд станцаас эхэлж, Дорноговь *аймгийн* төв Сайншанд хотын дэд станц хүрнэ. ЦДАШ нь Говь-сүмбэр *аймгийн* Сүмбэр, Шивээговь сумд болон Дорноговь *аймгийн* Даланжаргалан, Айраг, Сайхандулаан, Алтанширээ, Сайншанд сумдын нутгаар дайран өнгөрнө. Ерөнхийдөө, ЦДАШ-ын маршрут нь хүн ам сийрэг суурьшсан бөгөөд Говь цөлийн ургамалын бүрхүүлтэй нутгаар дайрах төлөвтэй.



Зураг 2-1. Цахилгаан дамжуулах агаарын шугам

2.3.2. Төлөвлөгөөт ажлууд

Төсөл нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ:

- **Цахилгаан дамжуулах агаарын шугам.** 220 км урттай 220 кВ-ын хоёр хэлхээт агаарын шугам нь Чойр дахь хуучин дэд станц болон Сайншандад баригдахаар төлөвлөгдсөн шинэ дэд станцын хооронд баригдана.
- **Тулгуур.** Хоёр хэлхээт ЦДАШ-г тулгуурын хоорондын зай нь урт байх шаардлагатай төмөр сараалжин цамхаг бүхий портал бүтэцтэй хос ган шонгуудаар тулна. Нийт 663 тулгуур ашиглагдана гэж төлөвлөж байгаа бөгөөд тулгуурууд 5 төрөл байна.
- **Дэд станцууд.** Төслийн хүрээнд ойролцоогоор 63 м2 талбай бүхий 220/110/35 кВ шинэ дэд станц Сайншандад баригдах ба мөн Чойрын дэд станцыг өргөтгөнө.

2.3.3. Хамгаалалтын зурвас байгуулах

2001 оны Монгол улсын Эрчим хүчний тухай хууль болон Монгол улсын Засгийн газраас 2020 оны 3-р сарын 18-нд баталсан 97-р Тогтоолд цахилгааны шугамд хамгаалалтын бүс эсхүл хамгаалалтын зурвас байгуулах тухай тусгасан байдаг. Эрчим хүчний дамжуулалтыг тасалдуулж болзошгүй аливаа үйл ажиллагааг Хамгаалалтын зурваст хориглоно. Үүнд дэд бүтцийн хөгжилтэй холбоотой үйл ажиллагаа

явуулахыг хориглоно. ЦДАШ-н Хамгаалалтын зурвас нь төв шугамаас хоёр талд тус бүр 25 м (нийт 50 м) газар алслагдмал нутгаар дамжин өнгөрнө. Суурин газруудад хамгаалалтын зурвасын хэмжээ шугамын аль аль тал руу 6 м болж буурна. Хамгаалалтын зурвасын эргэн тойронд мод ургамал эсхүл газар тариалан эрхлэхийг зөвшөөрөхгүй.

2.3.4. Барилгын үе шат

Барилгын шатанд дараах ажлууд явагдана:

- Талбай дээр хадгалах газар/бүрэлдэхүүн хэсгүүд, ажилчдын кэмп, талбайн нэвтрэх замууд байгуулах;
- Тоног төхөөрөмж болон ажилчдыг талбай руу тээвэрлэх;
- Барилгын ажил ба дэд станцын суурилуулалт;
- Шон болон цамхагийн суурийг тэгшлэх, малтах;
- Цамхаг/шонг босгох;
- ХЗ дахь тариаланг чөлөөлөх;
- Шугам татах;
- Хог хаягдлын менежмент;
- Тоног төхөөрөмжийн туршилт, анхны ашиглалт

Талбайд шаардлагатай барилгын тоног төхөөрөмжүүдэд дараах зүйлс орно:

- | | |
|---|------------------------------|
| • Экскаватор | • Бетон зуурагч |
| • Бульдозер | • Ачааны машин |
| • Ухаж гаргасан хөрс, шороо, барилгын материал, тоног төхөөрөмжийг тээвэрлэх зориулалттай өөрөө буулгагч ачааны машин | • Барилгын шат |
| | • Компакторууд/дагтаршуулагч |
| • Кран | • Механик хөрөө |
| • Сэрээт өргөгч, зөөгч машин | • Хөнгөн багаж хэрэгсэл |

Барилгын материалын хэмжээг батлагдсан зураг төслөөр шийдэх боловч, хамгийн бага материал орно гэж тооцоолж байна. Үүнд: суурийн бетон, ус, цахилгаан хангамж, барилгын агрегатууд болон замын материал зэрэг орно. Суурийн бетоныг талбай дээрх жижиг зуурагчаар (250 литрийн багтаамжтай) бэлтгэх эсхүл тохиромжтой зайд байрлах зуурмагийн үйлдвэрээс авах боломжтой. Үүнийг Барилгын ажлын гэрээт гүйцэтгэгч компаниуд тодорхойлно.

2.3.5. Ашиглалтын үе шат

Олон улсын стандарт болон Монгол Улсын Эрчим хүчний яамнаас тогтоосон үндэсний хууль тогтоомжид нийцсэн, практикт суурилсан тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээг хангана. Төслийн ашиглалтын шатанд хийж гүйцэтгэх үндсэн үйл ажиллагаанд дараах зүйлс багтана:

Дэд станцуудын үйл ажиллагаа, агаарын шугам, цамхаг, хамгаалалтын зурвасын хяналт шалгалт; ердийн, төлөвлөгөөт, яаралтай засвар, үйлчилгээ; ургамлын хяналт хийх.

2.4. Төслийн хувилбар

Талбайн байршил, зохион байгуулалт, үйл ажиллагааны явц, ашиглалтын талаарх төслийн хувилбаруудыг авч үзсэн. Цахилгаан эрчим хүчний хангамж, үр ашгийг нэмэгдүүлэх, дамжуулах, түгээх сүлжээнд үр ашгийг дээшлүүлэх, эрчим хүчний хөгжлийн талаарх дэвшүүлсэн зорилтыг биелүүлэхэд шаардагдах цахилгаан эрчим хүчний эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй байх магадлалын талаар "Төсөл байхгүй" хувилбарыг бас авч үзлээ.

Цахилгаан дамжуулах агаарын шугамын маршрутыг Чойр-Сайншандын гол замаар дайрч буй 110 кВ-ын цахилгааны шугамын ойролцоо байршилд байна гэж үзсэн хэдий ч энэ нь хангалттай хэмжээний газар биш тул хоёр сумын төв болон ил уурхайн дундуур өндөр хүчдэлийн шугам дамжин гарна гэж үзэж байна. Энэ нь илүү урт шугам тавих шаардлага үүсгэх бөгөөд өртөг өндөртэй болно гэсэн үг. Тиймээс хүн ам суурьшаагүй, алслагдмал газрыг сонгосон бөгөөд мөн уул уурхайн лицензит хоёр талбайг дайрахаас зайлсхийж 2021 онд шугамыг дахин шинэчилж, тохируулсан. Сонгосон эцсийн маршрутыг Зураг 2.1-т харуулав.

Сайншанд дахь шинэ дэд станцын байршлыг одоо байгаа дэд станц болон шинэ байршилд авч үзсэн. Дэд станцын шинэ байршлыг хуучин дэд станцаас хойд зүгт 2.5 км зайтай, илүү том газарт, Сайншандын төвөөс зайдуу байхаар төлөвлөөд байна.

Цахилгаан дамжуулах шугамд агаарын, газар доорх цахилгаан дамжуулах шугам гэсэн хувилбарууд бий. ЦДАШ нь газар доорх шугамаас хямд, ашиглалтын хугацаа урт, эвдэрч, сул зогсолт үүсэх нь бага байдаг зэрэг давуу талтай. (Доголдол, эвдрэлийг олж тогтооход хялбар бөгөөд засварлахад илүү хялбар). Мөн хэт ачааллыг тэсвэрлэх чадвартай. Цахилгаан дамжуулах агаарын шугамууд нь холболт хийх, салаалах болон өөрчлөхөд хялбар байдаг тул хэрэглэгчдэд найдвартай үйлчилгээ үзүүлэх боломжтой. Гэвч үүний эсрэгээр, агаарын шугамд цаг агаарын эрс тэс байдлаас буюу хүчтэй салхи, мөс тогтож ачаалал үүсгэх зэргээс үүдэн эвдрэл гэмтэл тохиолддог. Газар доор шугам тавих хувилбарууд нь олон нийтэд гэмтэл учруулах эрсдэл бага, илүү найдвартай (ө.х., богино болон урт хугацааны цахилгаан тасрах тохиолдол цөөн). Гэхдээ, газар доорхи шугамуудын кабелийг суулгасны дараа өөрчлөхөд бэрхшээлтэй болох бөгөөд илүү өртөг өндөртэй. Монгол улсад өмнө нь агаарын шугам тавигдаж байсан учраас энэхүү төсөлд агаарын шугамыг сонгосон. Цахилгаан дамжуулах цамхаг /пилон/ шонд ашиглаж болох материалын хувьд сонголтууд нь мод, бетон, ган болно.

Ган нь ихэвчлэн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамд ашиглагддаг тул төслийн үйл ажиллагаанд ашиглахаар сонгосон. Шонгийн (пилоны) бүтэц/хийц нь дан эсвэл давхар хэлхээг ашиглаж байгаа эсэх, эзлэх талбай, байгууламжийн зориулалт нь дүүжин, татлагат, терминал (шугамын төгсгөлд), эсвэл шилжүүлэн суулгах зэргээс хамаарна. Энэхүү төсөлд техникийн шаардлага, талбайн хэмжээг тусгахад ашиглах таван төрлийн бүтцийг тодорхойлсон.

3. Хууль эрх зүйн орчин, нийцэл

3.1. Үндэсний шаардлагууд

БОНБУ-ний шаардлагыг 1998 онд батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар зохицуулна. (2002, 2012 онд тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан). Хуулийн нэр томьёо нь бүх шинэ төслүүд, нөхөн сэргээлт, түүнчлэн одоо байгаа үйлдвэр, үйлчилгээ, барилга байгууламжийг өргөжүүлэх, байгалийн нөөцийг ашиглахтай холбоотой төслүүдэд хамаарна. Энэхүү төслийг хэрэгжүүлэхэд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас холбогдох зөвшөөрлийг авах шаардлагатай.

ЕСБХБ-ны төслийн БОННБУ-ний дагуу Эко Трөйд ХХК-ийн боловсруулсан БОННБУ-г Байгаль орчин, аялал жуулчлалын яамаар батлуулах болно.

3.2. ЕСБХБ-ны шаардлагууд

ЕСБХБ-ны шаардлагууд нь ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлагуудыг багтаасан байдаг. Энэхүү төсөлд хамаарах гүйцэтгэлийн шаардлагууд нь:

- Гүйцэтгэлийн шаардлага 1: Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, менежментийн үнэлгээ ба асуудлууд;
- Гүйцэтгэлийн шаардлага 2: Хөдөлмөрийн харилцаа, ажлын нөхцөл;
- Гүйцэтгэлийн шаардлага 3: Нөөцийг үр ашигтай ашиглах ба бохирдлоос сэргийлэх, хяналт;
- Гүйцэтгэлийн шаардлага 4: Эрүүл мэнд, аюулгүй байдал;
- Гүйцэтгэлийн шаардлага 5: Газар чөлөөлөлт, Албадан нүүлгэн шилжүүлэлт, Эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт;
- Гүйцэтгэлийн шаардлага 6: Биологийн олон янз байдлыг хамгаалах, Байгалийн нөөцийн тогтвортой менежмент;
- Гүйцэтгэлийн шаардлага 8: Соёлын өв;
- Гүйцэтгэлийн шаардлага 10: Мэдээллийн толилуулга, оролцогч талуудын оролцоог хангах.

Түүнчлэн ЕСБХБ нь Европын Холбооны (ЕХ) байгаль орчны бүх стандартад нийцэхийг шаардана.

Төсөлтэй холбоотой ЕХ-ны хамгийн их хамаарал бүхий Зааврууд нь төрийн болон хувийн хэвшлийн тодорхой төслүүдийн байгаль орчны нөлөөлөлд хийсэн үнэлгээний талаар ЕХ-ны Заавар 2011/92/EU, (2014/52/EU баримт бичгээр нэмэлт өөрчлөлт орсон) болон Шувууны заавар гэж нэрлэгдсэн Зэрлэг шувууг хамгаалах ЕХ-ны Заавар (2009/147/EC) юм.

ЕСБХБ нь мөн Орхусын Конвенци (Мэдээллийн хүртээмж, шийдвэр гаргахад олон нийтийн оролцоог хангах болон байгаль орчинтой холбоотой асуудалд хуулийн тэгш үйлчлэлийг хангах тухай), Эспүү конвенци (Хил дамнасан байгаль орчны үнэлгээний тухай) болон олон улсын хөдөлмөрийн байгууллагын голлох конвенциудын заавар, удирдамжийг дагаж мөрдөхийг эрмэлздэг.

БОННБУ-ний тодруулгын багцыг ЕСБХБ болон дээрх ЕХ, ОУХБ-ын шаардлагад нийцүүлэн боловсруулсан.

4. Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл ба бууруулах арга хэмжээний хураангуй

4.1. Танилцуулга


Суурь судалгааг баримт бичгийн хяналт судалгаа болон хээрийн судалгааны аргаар дараах байдлаар цуглуулсан:

- Биологийн олон янз байдал, байгаль орчны багийн төслийн талбайд хийсэн тандалт судалгаа 2020 оны 4-р сарын 15-аас 17-ны өдрүүдэд,
- Нийгмийн болон оролцогч талуудын баг төслийн талбайд хийсэн тандалт судалгаа 2020 оны 4-р сарын 19-өөс 22-ны өдрүүдэд
- Хаврын шувууны судалгаа, 2020 оны 5-р сарын 5-аас 15-ны өдрүүдэд
- Намрын шувууны судалгаа 2020 оны 9-р сарын 10-аас 20-ны өдрүүдэд
- Нийгмийн болон оролцогч талуудын оролцооны судалгаа, 2020 оны 6-р сарын 8-аас 12-ны өдрүүдэд
- Байгаль орчны судалгаа 1 (Газарзүй ба газрын хэвлий, ургамал, амьтан, ус, хөрс, замын хөдөлгөөн, хамгаалалттай газар нутаг), 2020 оны 6-р сарын 4-ээс 10-ны өдрүүдэд
- Байгаль орчны судалгаа 2 (Агаарын чанар, дуу шуугиан), 2020 оны 6-р сарын 12-оос 16-ны өдрүүдэд
- Уул уурхайн хоёр лицензит талбайгаас зайлсхийх зорилгоор шинэчилсэн трассын шугамын дагуу хийсэн талбайн хайгуул 2021 оны 5-р сарын 6-наас 7-ны хооронд

4.2. Барилгын үе шат


4.2.1. Газар нутгийн биологийн олон янз байдал, ургамал, амьтан

Төслийн бүсэд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн биологийн олон янз байдлыг хамгаалах талбай болох Их Нарт хэмээх шувууны чухал бүс байдаг. Энэхүү шувууны чухал бүс нь Их Нартын байгалийн нөөц газартай давхцаж байгаа бөгөөд ЦДАШ-н маршрутаас баруун зүгт 10 км-т оршдог. ШЧБ нь 43,740 га талбайг хамардаг ба Их Нартад 120 гаруй шувууны зүйл бүртгэгдсэн. Өөр нэгэн улсын тусгай хамгаалалттай газар нь ЦДАШ-н маршрутаас зүүн хойд зүгт 27 км-т байх Чойрын Богд байгалийн нөөцийн газар юм. Эдгээр талбайг Зураг 4-1-т харуулав.



Зураг 4 1. Төслийн бүс дэхь улсын тусгай хамгаалалттай газрын байршил

Чойр-Сайншандад орон нутгийн тусгай хамгаалалттай 47 газар бий. Төлөвлөгөөт ЦДАШ нь Зураг 4-2-т харуулснаар орон нутгийн хамгаалалтанд байдаг хоёр газрыг дайрна.



Зураг 4 2. Төслийн бүс дэх орон нутгийн тусгай хамгаалалттай газрын байршил

Биологийн олон янз байдлын судалгаагаар ургамлын бүрхэвч бага байсан бөгөөд Байгаль, байгалийн нөөцийг хамгаалах олон улсын холбоо (ББНХОУХ)-ны Улаан дансны зэрэглэлд орсон ховордсон ургамлын зүйл ажиглагдаагүй боловч Монгол Улсын Улаан дансанд бүртгэлтэй ховордсон ургамлын хоёр зүйл бүртгэгдсэн байна. Мөн хөхтөн амьтад, мөлхөгчид, сээр нуруугүй амьтад, шувуудын зүйл ажиглагдсан. Хаврын шувууны судалгаанд бүртгэгдсэн шувуудын ихэнх нь нэн тэргүүнд хамгаалах шаардлагатай шувууны зүйл биш хэдий ч ховордсон шувууны зүйл хоёр байгааг тогтоов. Ховордож болзошгүй биологийн олон янз байдлын зүйлүүдэд:

Ургамал:

- Шардалан (*Tugarinovia mongolica*) Монгол орны улаан дансанд ‘Устаж болзошгүй’, ‘Нэн ховор’ ургамлын зүйлд бүртгэгдсэн;
- Цөлийн аргамжин цэцэг (*Cistanche deserticola*). Монгол орны улаан дансанд “Устаж болзошгүй”, “Нэн ховор” ургамлын зүйлд бүртгэгдсэн.

Төслийн нөлөөллийн бүсэд хамрах бусад ургамлын зүйл устаж болзошгүй ургамлын зүйлийн ангилалд ороогүй.

Хөхтөн амьтад:

- Хар сүүлт зээр (*Gazella subgutturosa*). ББНХОУХ болон Монгол орны улаан дансанд Устаж болзошгүй зүйлд бүртгэгдсэн.
- Цагаан зээр (*Procapra gutturosa*). Монгол орны Улаан дансанд “Устаж байгаа” зүйлд бүртгэгдсэн;
- Аргаль (*Ovis ammon*). Монгол орны Улаан дансанд “Устаж болзошгүй” зүйлд бүртгэгдсэн;
- Янгир ямаа (*Capra Sibirica*). Монгол улсын хяналт, зохицуулалтын тодорхойлолтоор “Ховор” зүйлд бүртгэгдсэн

Шувууд:

- Хошуу галуу (*Anser cygnoid*). ББНХОУХ-ны Улаан дансны ‘Устаж болзошгүй’ зүйлд бүртгэгдсэн.
- Хонин тоодог (*Otis Tarda*). ББНХОУХ-ны Улаан дансны ‘Устаж болзошгүй’ зүйлд бүртгэгдсэн.
- Тарважи бүргэд (*Aquila nipalensis*). ББНХОУХ-ны Улаан дансанд “Устаж байгаа” зүйлд бүртгэгдсэн;
- Идлэг шонхор (*Falco cherrug*). ББНХОУХ-ноос “Устаж болзошгүй,” Монгол орны Улаан Номонд “Эмзэг” зүйлд бүртгэгдсэн;
- Нөмрөг тас (*Aegypius monachus*). ББНХОУХ-ны Улаан дансанд ‘Ховордож болзошгүй’ ангиллын зүйлүүд; цахилгаан дамжуулах шугамтай мөргөлдөх, олон тоогоор цахилгаанд цохиулах эрсдэл өндөр.
- Ойн шийхнүүхэй (*Anthus trivialis*). Монгол улсын хяналт, зохицуулалтын тодорхойлолтоор “Ховор” зүйлд бүртгэгдсэн;
- Монгол ногтруу (*Syrnhaptus paradoxus*). Төслийн талбайд цахилгаан дамжуулах шугамтай хамгийн их мөргөлддөг, мөргөлдөх эрсдэлтэй зүйл;
- Дорнын хиазат (*Charadrius veredus*). Нийгэм эдийн засгийн хувьд үнэ цэнэтэй зүйл. Цахилгаан дамжуулах шугамтай мөргөлддөг;
- Бусад үүрлэдэг шувууны зүйл.

Түр болон байнгын талбайн үйл ажиллагаанаас ургамал, амьтны амьдрах орчны шууд алдагдал, байгалийн амьдрах орчны доройтол, амьтдад саад учруулах, нүүлгэн шилжүүлэлт зэрэг сөрөг нөлөөлөл учирч болзошгүй хэдий ч эдгээр нөлөөлөл бага байх төлөвтэй байна. Барилгын үйл ажиллагаа, тоног төхөөрөмжийн менежментийн дутагдал, шингэн бодис санаандгүй асгарсаны улмаас хөрс бохирдох зэрэг байгаль орчинд хохирол учирч болзошгүйг анхаарах нь зүйтэй.

Том хөхтөн амьтдад үзүүлэх болзошгүй шууд нөлөөлөл нь Төслийн барилгын талбай эдгээр зүйлийн бүс нутгийн амьдрах орчинтой давхцаж байгаагаас төслийн тээврийн хэрэгслүүдтэй мөргөлдөх эрсдэл юм.

Барилгын үйл ажиллагаанаас шувууны зүйлд учруулах нөлөөлөл, түр болон байнгын талбайн үйл ажиллагааны улмаас амьдрах орчны алдагдал, шувууны үүр, үүрлэх амьдрах орчин, үржлийн зан байдалд саад учрах, үүрээ орхих зэргээр хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй болзошгүй нөлөөллийг мөн авч үзсэн.

Харь зүйлийг нутагшуулах нь уугуул зүйлд аюул учруулж болзошгүй хэдий ч хуурай бүсийн уур амьсгал, хөрсний нөхцлийг тооцоход нутагшуулсан зүйлүүд аюул учруулахгүй гэж үзэж байна. Харин төслийн

ажилтнууд ургамал, амьтны гаралтай зүйлийг цуглуулах, зэрлэг амьтан агнах зэргээр зүйлд заналхийлж болзошгүй юм

Дараах сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр ЦДАШ-ын барилгын ажлаас ургамал, хөхтөн амьтад, шувууны зүйлд үзүүлэх сөрөг нөлөөлөл бага байна гэж үзэж байна.

Дараах бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- Тариаланг цэвэрлэх үйл ажиллагаа явуулахад газар хөндөх зөвшөөрөл авах шаардлагатай бөгөөд тариалан цэвэрлэх үйл ажиллагаа, төлөвлөсөн ажилд ногдох нөхцлийг бүрдүүлэх зорилгоор газар хөндөх урьчдигдсан судалгааг явуулна.
- Барилгын кэмп барих газар, түр нэвтрэх замын байршлыг сонгоходоо газар хөндөхийн өмнөх судалгаанд үндэслэн эмзэг өртөмхий зүйлүүд, бүс нутгаас зайлсхийнэ. Боломжтой тохиолдолд нэвтрэх замуудад аль болох хуучин шороон замыг ашиглана.
- Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. Зэрлэг амьтдын зам тээврийн осолд өртөх эрсдлийг бууруулахын тулд тээврийн хэрэгслийн хурдны хязгаарлалтыг мөрдөнө.
- Төслийн бүх ажилчдад ховор ургамал, амьтны гаралтай зүйл цуглуулах, худалдаж авах, эсхүл хохирол учруулахыг хориглоно. Энэ талаар сургалт явуулж, зохих мэдлэг олгоно.
- Нөлөөлөлд өртсөн бүх газрыг нөхөн сэргээнэ.

4.2.2. Хөрс

Ургамал цэвэрлэхэд хөрсний элэгдэл, нягтрах, хөрс эвдрэх зэрэг болзошгүй нөлөөлөл түүнчлэн барилгын үйл ажиллагааны үеэр хөрсний бохирдол үүсэх эрсдэлтэй. ЦДАШ нь мал бэлчээрлэдэг газарт баригдана. Тулгуурийн суурь болон Чойрын дэд станцын ажилд хөрс ухах ажил хийгдэнэ. Зориулалтын бус талбайд шимт хөрсийг хадгалах (Жишээ нь хөрсний овоолго хэт өндөр) эвсэл хөрсийг хэт удаан удаан хугацаанд хадгалах нь хөрсний бүтэц алдагдахад хүрч болзошгүй. Мөн шингэн бодис санамсаргүй асгарсанаас хөрсний бохирдол үүсэх эрсдэлтэй бөгөөд Чойрын хуучин дэд станцын эргэн тойрны газар бохирдсон хөрс байж болзошгүй юм.

Дараах төлөвлөгөөт бууруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бага байлгах боломжтой.

Дараах бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- Хөрсний менежментийн төлөвлөгөө, Шингэн бодис асгарахаас сэргийлэх, Онцгой байдлын үед авах арга хэмжээ, бэлэн байдлын төлөвлөгөө, Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг тус тус хэрэгжүүлнэ.
- Гэрээт гүйцэтгэгч нь Барилгын тээврийн хэрэгслийн замын төлөвлөгөөг боловсруулах ба олон зам гарахаас сэргийлэн *Сумын* удирдлагаас зөвшөөрөл авч, зөвшөөрөлтэй замаар тээврийн хэрэгсэл явуулна.
- Гэрээт гүйцэтгэгч нь Монгол Улсын стандартын дагуу өнгөн хөрсийг хуулж, хадгалах ба салхи, бороонд элэгдэх, хог хаягдал, бусад материалын бохирдлоос хамгаалж, салхитай үед хөрс хуулахгүй.
- Барилгын талбайг зүй зохистой зохион байгуулж, зэргэлдээх талбайд учруулах сөрөг нөлөөлөл, хохирлыг багасгах үүднээс стандарт шаардлагад нийцүүлэн удирдана.
- Гэрээт гүйцэтгэгч нь барилгын үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн газрыг нөхөн сэргээнэ.

4.2.3. Усны нөөц

Бүс нутагт байгалийн гол мөрөн, горхи байхгүй боловч борооны ус хурах түр урсацтай хуурай голын сайр, борооны усаар тэжээгддэг давстай нуур, булаг шандны усаар тэжээгддэг хуурай нуурын ором зэрэг идэвхитэй ус хурах газар бий. Газар доорхи ус нь гол ус хангамж юм.

Барилгын ажил, ажиллах хүчний хэрэгцээнээс үүдэн гадаргын болон газар доорхи усны нөөцөд нөлөөлөл учирч болзошгүй ба энэ нь орон нутгийн усны нөөцөд сөрөг нөлөөлөл учруулж болзошгүй ба барилгын талбай цэвэрлэх, барилгын үйл ажиллагаа нь байгалийн ус зайлуулах горимыг өөрчлөх, шингэн бодис санамсаргүй асгарсанаас бохирдох зэрэг эрсдэлийг бий болгож болзошгүй. Мөн түүнчлэн Барилга угсралтын явцад санамсаргүй үйл ажиллагааны улмаас гүний усны худагт сөрөг нөлөөлөл учруулж болзошгүй.

Гүний усны худаг гаргаж, барилгын усны хэрэгцээнд ашиглах төлөвтэй байна.

Жилийн ихэнхи хугацаанд хуурайшилттай байдаг ч ЦДАШ-ын коридор дахь 31 голын суваг их хэмжээний хур тунадасын үеэр үерийн усыг эргүүлэхэд гол хүчин зүйл болдог ба барилгын ажилчид борооны үеэр үерийн эрсдэлтэй газар барилга угсралтын ажил явуулах, чанарын шаардлага хангаагүй барилгын

ажлын талбай, ус зайлуулах хоолой нь орон нутгийн малчдын гэр, хогшил үерт автах эрсдлийг нэмэгдүүлж болзошгүй.

Дараах бууруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр усны нөөцөд үзүүлэх нийт нөлөөлөл гүний усны нөөцийн хомсдолд дундаас бага зэрэг сөрөг нөлөө, гүний усны хүртээмжийн бага зэргийн сөрөг нөлөөг эерэг, усны бохирдол, үерийн эрсдэлд бага зэрэг сөрөг нөлөө, гадаргын усны гидрологид үл ялиг сөрөг нөлөөтэй болно.

Дараах бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- Усны менежментийн төлөвлөгөө, Шингэн бодис асгарахаас сэргийлэх, Онцгой байдлын үеийн арга хэмжээ, бэлэн байдлын төлөвлөгөөг авч хэрэгжүүлнэ.
- Урьдчилсан зөвшөөрөл авахгүйгээр гадаргын болон газар доорхи усыг ашиглахгүй.
- Гэрээт гүйцэтгэгч нь усны хэрэглээнд хяналт тавих, зөвшөөрөлтэй гүний усны худгаас ус олборлох ба малчдын худагт сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байхад хяналт тавьж ажиллана.
- Гэрээт гүйцэтгэгч нь байнгын болон түр барилгын ажлыг хуурай голын эрэг, гольдролоос 50 м-ийн зайд хийж гүйцэтгэхийг хориглох бөгөөд барилгын ус зайлуулах хоолой үерийн эрсдлийг нэмэгдүүлэхгүй байхад анхаарч, барилгын үйл ажиллагааны улмаас орон нутгийн өмч хөрөнгөд үерийн эрсдэл учруулахгүй байхад анхаарч ажиллана.
- Гэрээт гүйцэтгэгч нь голын суваг, түр урсацын урсгалыг өөрчлөх хүчин зүйл үүсгэхгүй ба түр урсацад тулгуурыг байрлуулахгүй байх.
- Төслийн усны эх үүсвэрт малчдын худгийг ашиглахгүй. Орон нутгийн малчдын худгийн газрын зургийг төслийн талбайн хажууд буулгах ба тэдгээр худгийг төслийн талбайгаас зааглан, эвдрэлээс хамгаална. Барилгын үйл ажиллагааны улмаас алдагдсан худгийг дахин барина.

4.2.4. Агаарын чанар

Барилгын ажлын явцад агаарын чанарт үзүүлж болзошгүй гол нөлөөлөл нь тоос, хийн ялгарал үүсэхтэй холбоотой нөлөөлөл байна. Газар шорооны ажил явуулах үеэр хөрс хуулах ба энэ нь салхитай үед тоос үүсгэнэ. Барилгын ажил нь талбайн бэлтгэл ажил, малтлага, барилгын үйл ажиллагаа, хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний улмаас тоос үүсгэнэ. Мөн Бетон зуурмагийн үйлдвэр нь их хэмжээний тоос ялгаруулж болзошгүй юм.

Орон нутгийн агаарын чанарт удаан хугацааны эсхүл өргөн хүрээний томоохон өөрчлөлт оруулах магадлал багатай ч тоос шороо оршин суугчдын тулгамдсан асуудал болсон бүсэд Төслийн талбай байрлаж байгаа бөгөөд гэр сууц нь тоос шороо орохоос сэргийлсэн шилэн цонхгүй зэрэг нөхцлийг бодолцох нь зүйтэй. Барилгын замаас 50 метрийн зайд, барилгын үйл ажиллагаа явуулж буй талбайгаас 350 м-ийн зайд байх цөөн тооны малчин өрхөд эдгээр нөлөөлөл түлхүү мэдрэгдэх хандлагатай.

Барилга угсралтын явцад хий ялгаруулах гол эх үүсвэр нь материал тээвэрлэхэд ашигладаг барилгын машин, тоног төхөөрөмж, ачааны машинаас гарна. Хийн ялгарлаас гарах агаарын чанарт үзүүлэх хамгийн том нөлөөлөл нь төслийн талбай руу нэвтрэх бүсэд бий болно.

Дараах бууруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр барилгын ажлын явцад тоосжилтын агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл дунд зэргээс бага (цаг агаарын байдал нөлөөлнө) ба хийн ялгарлын сөрөг нөлөөлөл бага байхаар тооцож байна. Эдгээр нөлөөллүүд нь барилгын ажил явагдах үеэр гарах буюу түр зуурын нөлөө үзүүлнэ.

Дараах бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- Монгол улсын тоосжилтын стандартын нийцлийг дагаж мөрдөх (MNS 4585: 2007).
- Салхитай үед хөрс хуулалт хийхийг хориглох ба хэрэв төслийн ажлын хуваарь шахуу бол ус шүрших аргыг хэрэглэнэ.
- Барилгын тээврийн хэрэгсэл нь хий ялгаруулах стандартыг хангаж, олон газраар шороон зам үүсгэхгүйн тулд батлагдсан маршрутуудыг чанд мөрдөнө.
- Зам дагуу газраар болон газар шорооны ажил явагдах газарт тоосжилт дарах ажлыг тогтмол явуулна.
- Гэрээт гүйцэтгэгч нь малчин өрхүүдэд барилгын ажлын хуваарийг урьдчилан мэдээлж, Орон нутгийн иргэдийн гомдол шийдвэрлэх механизмыг боловсруулна.

Хяналт шинжилгээний шаардлагууд:

- Шаардлагатай тохиолдолд сонгосон газруудад тоос ялгаруулалтыг хянах (жишээ нь, барилгын ажилд ойрхон малчин өрхүүд).

4.2.5. Дуу шуугиан, доргио чичиргээ

Барилгын ажлын явцад барилгын үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн; бетон зуурмагийн үйлдвэр нь дуу шуугиан, доргио чичиргээ үүсгэх эх үүсвэр болно. Төлөвлөгөөт ЦДАШ-ын коридор нь дуу шуугиан бага, дуу шуугиан тогтвортой газарт байрладаг.

Малтлага, дэд станц, цахилгаан дамжуулах шугам барих ажил нь дуу чимээний гол эх үүсвэр болох төлөвтэй, гэвч эдгээр газрууд ерөнхийдөө суурин газраас хол байрлана. Барилга угсралтын явцад хийгдэх үйл ажиллагаан дээр үндэслэн дүгнэхэд ойр орчимд, тухайлбал малчин өрхүүдэд тодорхой хэмжээгээр сөрөг нөлөөлөл үүсэх нь гарцаагүй хэдий ч барилгын ажлын явцад дуу шуугианаас үүсэх сөрөг нөлөөлөл нь түр зуурын, ихэнх хэсгүүд хязгаарлагдсан бүсэд хамаарна.

Доорх төлөвлөж буй бууруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр барилгын ажлын явцад дуу шуугиан, доргио чичиргээний нөлөөлөл хот, суурин газрын ойролцоо амьдрах орон нутгийн иргэд, малчин өрхүүдэд дундаас бага зэрэг, ЦДАШ-ын маршруттай ойр байх өвөлжөө, малчин өрхүүдэд учрах сөрөг нөлөөг дундаас бага зэрэг болгон бууруулах боломжтой.

Дараах бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- Барилгын ажлын талаар орон нутгийн иргэдэд урьдчилан анхааруулах (ө.х барилгын ажлын хуваарийг танилцуулах гэх мэт). Олон нийтийн гомдол шийдвэрлэх механизмыг боловсруулна.
- Тээврийн хэрэгсэл, машин механизмын дуу чимээ үүсгэх төвшин үндэсний болон олон улсын стандартад нийцсэн байна.
- Нөлөөлөлд мэдрэмтгий өртөгчдийн ойролцоо дуу чимээ ихтэй үйл ажиллагаа явуулах байршил, үргэлжлэх хугацааг хязгаарлана.
- Зайлсхийх боломжгүй ажлаас бусад дуу шуугиан үүсгэх ажлыг өдрийн цагаар явуулахгүй. Хэрэв шөнийн цагаар үйл ажиллагаа явуулах шаардлагатай бол болзошгүй нөлөөлөлд өртөгчдөд урьдчилан анхааруулна.

Хяналт шинжилгээний шаардлагууд:

- Шаардлагатай тохиолдолд сонгосон газруудад дуу шуугиан, доргио чичиргээг хянах (жишээ нь, барилгын ажилд ойрхон малчин өрхүүд).

4.2.6. Замын хөдөлгөөн, тээврийн хэрэгсэл

Барилга угсралтын үеэр барилгын тээврийн хэрэгслүүд Чойр, Сайншандын хоорондох гол замыг барилгын талбайд нэвтрэхэд ашиглах шаардлагатай бөгөөд ингэснээр орон нутагт замын хөдөлгөөний ачаалал, түгжрэл үүсгэж болзошгүй юм. ЦДАШ-н Хамгаалалтын зурвасын замыг тээврийн хэрэгсэл явах замаар ашиглах бөгөөд хуучин замуудыг боломжтой газруудад ашиглах ба мөн гол замаас ЦДАШ-ын чиглэлд нэмэлтээр түр зуурын эсхүл байнгын нэвтрэх зам шаардлагатай болох төлөвтэй. Зам руу нэвтрэх, Хамгаалалтын зурвасын замыг тээврийн хэрэгслийн зориулалтаар ашиглах нь орон нутгийн зам ашиглагчид, ялангуяа малчид болон тэдний мал сүрэгтэй зөрчилдөөн үүсгэж болзошгүй. Гэсэн хэдий ч аливаа хүндрэл чирэгдэл түр зуурынх байна.

Доорх бууруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр тээврийн хэрэгсэл болон замын хүртээмжид үзүүлэх сөрөг нөлөөлөл бага байна гэж үзэж байна.

Дараах бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.
- Боломжтой тохиолдолд Хамгаалалтын зурвасын замыг тээврийн хэрэгслийн зам болгон шинээр зам гаргах хэрэгцээг бууруулна.
- Гомдол барагдуулах механизмыг бий болгоно.

4.2.7. Материалын хэрэглээ ба Хог хаягдлын менежмент

Түүхий эд, материалыг ашиглах, үүссэн хог хаягдлыг зайлуулах ажил барилгын явцад үүснэ. Шаардлагатай үндсэн нөөцөд дүүргэгч, бетон, ус орно. Байгалийн болон сэргээгдэхгүй нөөцийн хэрэглээ нь материалын нөөцөд сөргөөр нөлөөлнө. Шаардлагатай тоо хэмжээний талаархи тодорхой мэдээлэл одоогоор байхгүй; Үүсэх нөлөөлөл нь шаардагдах хэмжээ, материалын үүсэл, эх үүсвэр, тэдгээрийн боломжит байдлаас хамаарна. Ихэнх материалыг одоогийн нөөцөөс авч ашиглах бөгөөд энэ нь хайрга дайргын карьер шинээр олборлох, ашиглах сөрөг нөлөөллийг бууруулна.

Барилга угсралтын явцад аюултай болон ахуйн хог хаягдал хоёуланг нь бий болгоно. Хог хаягдал үүсгэх, хадгалах, зайлуулахад сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй. Таамаглаж буй хогны төрөлд малтлага, барилгын материал, хатуу хог хаягдал, бохир ус орно. Барилгын хог хаягдал, сав баглаа боодлын хаягдал, хаягдал мод, метал зэрэг ахуйн хог хаягдал, ашигласан тос, хоосон бул болон барилгын машин, механизмын сэлбэг хэрэгсэл зэрэг аюултай хог хаягдлыг зохисгүй зайлуулах тохиолдолд байгаль орчны бохирдол үүсгэж болзошгүй юм.

Ухсан хөрсийг үүсгэх гол ажил нь Сайншанд дахь дэд станц болон ЦДАШ-ын маршрутын дагуу байрлах тулгуур багануудын малтлага юм. Боломжтой тохиолдолд талбайн материалыг дахин ашиглах (жишээ нь, дахин дүүргэх) нь зам дээрх тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг багасгаж, орон нутгийн хог хаягдлын менежментийн дэд бүтцийн ачааллыг бууруулах талтай.

Төслийн талбайд хатуу хог хаягдлын менежментийн дэд бүтэц хязгаарлагдмал байдаг. Хаягдал зайлуулах зориулалтын цэг байхгүй ч Чойрын гадна талд хог овоолгын цэг бий. Тиймээс хог хаягдлын менежментийн талаар тодорхой зохицуулалтыг орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтран хийх шаардлага үүсэж болно.

Доорх бууруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр ашиглалтын болон хог хаягдалд үзүүлэх нийт нөлөөлөл хог хаягдлыг зайлуулах эцсийн арга хэмжээнээс хамааран аюултай хог хаягдлын менежментэд бага зэрэг сөрөг нөлөөтэй, Ахуйн хог хаягдлаас үзүүлэх дунд сөрөг нөлөө бага болон буурна.

Дараах бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- Материал ашиглах, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, шингэн бодис асгарахаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.
- Хог хаягдлын шатлалыг эх үүсвэр дээр хаягдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, нөөцийг үр ашигтай ашиглах, менежментийг хангах, боломжтой тохиолдолд хаягдлыг нөхөн сэргээх зорилгоор төслийн төлөвлөгөөнд ашиглана.
- Хог хаягдлын зөвшөөрлийн бичиг /тусгай зөвшөөрлийг авна.
- Хог хаягдлыг хадгалах, цуглуулах, тээвэрлэх, зайлуулах ажлыг хууль ёсны шаардлагын дагуу лицензтэй / зөвшөөрөлтэй компаниуд гүйцэтгэнэ.
- Хог хаягдлыг Төслийн тодорхойлсон зориулалтын хаягдлын цэгт зайлуулна.

4.2.8. Газар ашиглалт, Газар эзэмших болон нүүлгэн шилжүүлэлт

Уг төслийн хүрээнд Сайншанд Салхин Цахилгаан станцын талбайн шинэ дэд станцын барилга угсралт болон төслийн маршрут дагуух ЦДАШ-ын цамхагийн сууриудын барилга угсралтад газар эзэмших шаардлагатай. Хамгаалалтын зурвас дотор ургамал түр хугацаанд тайрах боловч агаарын шугам ашиглалтанд орсны дараа бүх үйл ажиллагааг хязгаарлах явдал гарахгүй. Мөн барилга байгууламж, нэвтрэх зам (тээврийн хэрэгсэл) гэх мэт барилгын талбай дээрх байгууламжид түр хугацаагаар газар эзэмших шаардлагатай болно. Одоо ашиглагдаж буй хайрга, дайргын карьерыг боломжтой газарт ашиглана.

Сайншанд дахь дэд станцын талбай одоогоор ашиглалтгүй байгаа бөгөөд Хамгаалалтын зурвасын 25 м орчим талбайд бизнесийн үйл ажиллагаа явуулж буй болон орон сууцны зориулалттай барилга байгууламж байхгүй тул дэд станц одоогийн газар ашиглалтад нөлөөлөхгүй ба биет, эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт хийгдэх шаардлагагүй. Чойрын хуучин дэд станцад хамгийн ойр байрлах барилга байгууламж нь төмөр замын нөгөө талд байх тосгоны үйлдвэрийн барилгууд байна. Иймд талбайн ажлууд нь одоогийн газар ашиглалтад нөлөөлөхгүй ба биет болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт үүсгэхгүй.

Чойр, Сайншандын дэд станцуудын хоорондох ЦДАШ-ын маршрут нь дийлэнхдээ хээр тал, бэлчээрийн газраар дамжин өнгөрнө. ЦДАШ дамжин өнгөрөх газарт хэд хэдэн уурхайн лицензит газар, малчны эзэмшлийн гэрчилгээтэй газар (доор тайлбарласан) байх ч үндсэндээ бүгд төрийн өмчит газар юм. ЦДАШ-ын маршрутын газрыг орон нутгийн удирдлага төсөлрүү хуваарилах ажил хийгдэж байгаа бөгөөд тушаал гарахад асуудал гарахгүй гэж үзэж байна. Гэхдээ эцсийн маршрутын зураг төслөөс хамааран эзэмшлийн гэрчилгээтэй газар эзэмшигч малчид, одоогийн маршрутыг дайрч өнгөрөх хайгуул ашиглалтын дөрвөн лицензит газар эзэмшигчид болон орон нутгийн тусгай хамгаалалттай хоёр газар болох Тогоотын Хонхор ба Борнуруу зэрэг сум орон нутгийн эзэмшлийн газарт нөлөөлж болзошгүй. (Зураг 4.2) .

Одоогийн байдлаар ЦДАШ-ын Хамгаалалтын зурвасын маршрутын дагуу түр болон байнгын эзэмшлийн малчин өрхийн байгууламж байхгүй боловч хэд хэдэн малчин өрх Төслийн нийт талбайд бүртгэлтэй байдаг. 6-р сард ихэнх айлууд зусланд гардаг ч зарим нь өвөлжөөндөө (ЦДАШ-ын маршруттай ойрхон) үлддэг. Иймээс ЦДАШ-ын дагуу орон сууцны зориулалттай барилга байгууламжийн биет нүүлгэн

шилжүүлэлт хийгдэхгүй. Хамгаалалтын зурваст байрлах худаг тогтоогдоогүй. Гэсэн хэдий ч малчдад үүсэх түр зуурын шинж төлөв, эцсийн зураг төсөлд гарч болзошгүй өөрчлөлтийг харгалзан маршрутын эцсийн зураг төсөл сонгогдсоны дараа эдгээр таамаглалыг баталгаажуулах зорилгоор цаашдын судалгааны ажлыг хийх болно.

ЦДАШ-ын барилгын үйл ажиллагаа бэлчээрийн түр алдагдал бий болгож энэ нь малчдад сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй ч ихэнхи малчин өрхүүд зусландаа гарсан байх зуны улиралд барилгын ажил явагдах ба тэдгээр бэлчээрийн газрууд байршлын хувьд илүү уян хатан байх тул нөлөөлөл бага байна гэж үзэж байна. Гэсэн хэдий ч барилгын үйл ажиллагааны улмаас хязгаарлалт үүсэх үед бэлчээрт нөлөөлөх зарим түвшинг бий болгоно.

Доорх бууруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр газар ашиглалт, газар эзэмших, нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой бага зэрэг сөрөг нөлөөлөл үл ялиг болно гэж үзэж байна..

Дараах бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- Цамхагийн тодорхой байршлыг тогтоохын тулд шугамын маршрутын судалгааг хийх шаардлагатай. Эцсийн коридор болон цамхагийн байршлыг хянаж үзэх шаардлагатай бөгөөд эцсийн коридор доторх аливаа нөлөөлөлд өртсөн хөрөнгийг (жишээлбэл малчны худаг, зуслан) тодорхойлох бөгөөд эдгээр зүйлсийг оруулахаас аль болох зайлсхийлнэ. Хэрэв ямар нэгэн биет болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт хийх бол (үүнээс зайлсхийхийн тулд зураг төслийг өөрчлөх боломжгүй бол) нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө ба / амьжиргаа нөхөн сэргээх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.
- Цамхаг, түр ажлын талбай, нэвтрэх замуудын эцсийн байршлыг сонгохдоо Төсөл хэрэгжүүлэгч ба гэрээт гүйцэтгэгч нь орон нутгийн засаг захиргаа, уурхайн лизензит газар эзэмшигч, малчидтай зөвлөлдөх шаардлагатай. Эзэмшлийн гэрчилгээтэй газартай малчдад мөн анхаарал хандуулах хэрэгтэй.
- Хамгаалалтын зурвас, барилгын ажлын талбайг цэвэрлэх, үргэлжлэх хугацааг малчдад урьдчилан мэдэгдэж, зохих арга хэмжээ авах боломжийг олгоно.
- Үйл ажиллагаа явуулах хугацааг малчдад үзүүлэх нөлөөллийг аль болох багасгах зорилгоор тодорхойлох, Жишээ нь. Төслийн талбайн ойр орчим цөөн малчин байх зуны саруудад үйл ажиллагаа явуулах.
- Гэрээт гүйцэтгэгч нь боломжит зам, гарцын дахин ашиглахыг зорино. Ашиглаж дууссаны дараа түр зуурын замыг сэргээн засварлана.
- Цэвэрлэгээ, барилгын ажил явуулах газар нь зориулалтын ажлын хүрээгээр хязгаарлагдана.
- Гомдол шийдвэрлэх механизмыг хэрэгжүүлнэ.

Хяналт шинжилгээний шаардлагууд:

- Шаардлагатай тохиолдолд эд хөрөнгийг нүүлгэн шилжүүлэхэд учирсан хохирлын нөхөн төлбөрт хяналт тавих.

4.2.9. Хөдөлмөр эрхлэлт, эдийн засаг, амжиргаа

Төслийн барилга угсралтын үе шат улс, бүс нутаг, орон нутгийн эдийн засаг, хөдөлмөр эрхлэлтэд хэд хэдэн эерэг үр дүн, ашиг тус авчирна. Барилга угсралтын үе шат нь 24 сар байх ба энэ хугацаанд хязгаарлагдмал, богино хугацааны шууд ажлын байр бий болох боломж нээгдэх болно. Түүнчлэн орон нутгийн үйлчилгээ, бараа бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэнэ. Хэрэв барилгын ажлыг орон нутгийн компаниудаар явуулах, гэрээт гүйцэтгэгчдийн хэрэгцээг орон нутгаас хангаснаар орон нутгийн бизнесийг сурталчлах ба улмаар орон нутагт авчрах ашиг тусыг нэмэгдүүлэх юм.

Төслийн талбайд ажилгүйдэл залуучуудад (16-34 насныхан) хамгийн өндөр байгаа тул төслийн барилгын үе шат нь ялангуяа төслийн ажилчид болон тэдний гэр бүлд мэдэгдэхүйц шууд үр ашгийг өгөх ба тэд үүгээр санхүүгийн баталгаа болон өргөн хүрээний үр чадвар, туршлагыг харьцангуй түргэн хугацаанд олж авах боломжтой.

Доорх бууруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт, амьжиргаанд үзүүлэх дунд зэргийн эерэг нөлөөлөл үүснэ гэж үзэж байна.

Дараах бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- Хөдөлмөрийн менежментийн төлөвлөгөө, гомдол шийдвэрлэх механизмыг боловсруулна.
- Гэрээт гүйцэтгэгч нь орон нутгаас бараа бүтээгдэхүүн худалдан авах, орон нутгийн бараа, үйлчилгээ ашиглахыг дэмжих, орон нутгийн худалдан авалт, ажиллах хүч татах журам боловсруулна.

- Гэрээт гүйцэтгэгч нь ажиллах хүч татах үйл явцыг хөдөлмөрийн насны, ажил хийх чадвартай орон нутгийн бүх хүмүүст (эмэгтэйчүүдийг оруулах) ил тод, нээлттэй явуулна.
- Гэрээт гүйцэтгэгч нь орон нутгийн ажиллах хүчийг шаардлагатай сургалтанд хамруулж ажиллуулах ба орон нутгийн удирдлагатай хамтран орон нутгийн ажилчдыг ялгаварлах явдлыг бууруулж ажиллана.

4.2.10. Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал

Барилгын ажлын үед замын хөдөлгөөн нэмэгдэх, барилгын материал, тоног төхөөрөмж унах, цамхагийн суурийг хамгаалалтгүй ухах (хүүхэд, амьтдад эрсдэлтэй), машин механизмын хяналтыг алдах зэргээс үүдэлтэйгээр гэмтэх зэрэг олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд учрах эрсдэлүүдийг бодолцох ёстой. Барилгын ажлын үеэр замын хөдөлгөөн нэмэгдэх, тоног төхөөрөмж хэрэглэх, хамгаалалтын зурвасын талбайгаас тоос шороо үүсэх, түргэн тусламжийн үйлчилгээний ачаалал, дуу чимээ, тоос шороо нэмэгдэх зэргээс олон нийтийн эрүүл мэндэд учрах эрсдэл нэмэгдэнэ.

Барилгын ажлын талбайд нэвтрэхийг хязгаарлах учраас гэмтлийн эрсдэлийн гол эх үүсвэр нь барилгын ажлын замын хөдөлгөөн байна. Эдгээр болзошгүй нөлөөллүүд нь үндсэн зам болон Чойрын дэд станцын ойролцоо амьдардаг иргэд болон малчдад хамаарна. ЦДАШ-ын маршрутын эргэн тойрны нутагт малчдын мал сүрэг бэлчдэг тул маршрутаас хамааран зам дээр яваа барилгын машин техниктэй мөргөлдөх нэмэлт эрсдэл бий болно.

Барилга угсралтын ажиллах хүч ирсэнээр орон нутаг руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой эрсдэлүүдийг үүсгэж болох ба өөр бүс нутгаас ажилчид ирсэнээр орон нутагт ялангуяа эмэгтэйчүүдэд эрсдэл учруулж болзошгүй. Төслийн ажиллах хүчийг барилгын түр кэмпэд байрлуулах бөгөөд нийтдээ гурван кэмп барих шаардлагатай байж болзошгүй. Орон нутгийн бус ажилчид орж ирсэнээр таагүй байдал, үймээн, жендерт суурилсан хүчирхийлэл нэмэгдэх, бэлгийн замын халдварт өвчин тархах зэргээр эрүүл мэндийн эрсдэл учруулж болзошгүй.

Доорх бууруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх сөрөг нөлөөлөл бага байна гэж үзэж байна.

Дараах бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө, олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хамгаалалтын төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.
- Гомдол шийдвэрлэх механизмыг хэрэгжүүлнэ.
- Осол аваарын эрсдэлийг бууруулахын тулд барилгын замын хөдөлгөөнд хурдны хязгаарлалт тавина.
- Гэрээт гүйцэтгэгч нь барилгын ажил болон зохих эрсдэлүүдийн талаар орон нутгийн иргэд, замын хөдөлгөөнд оролцогчдод мэдүүлэх үүднээс ажил эхлэхийн өмнө орон нутагт мэдээлэл түгээх ажил явуулах.
- Ажилчдад зориулсан танилцуулах хөтөлбөрт олон нийтийн мэдлэг, хариуцлагын талаарх сургалтыг оруулж Төслийн ёс зүйн дүрмийн талаарх сургалтанд бүх ажилчдыг хамруулах.
- Гэрээт гүйцэтгэгч нь малчдын өвөлжөө, малчдын ашиглаж буй бусад байгууламжаас дор хаяж 500 м-ээс доошгүй зайд ажлын кэмп, байгууламж, агуулах, нэвтрэх замыг сонгон байршуулах шаардлагатай.
- Гэнэтийн нөхцөл байдалд хариу арга хэмжээ авах төлөвлөгөө бэлтгэх ба үүнд орон нутгийн иргэдэд үзүүлэх нөлөөлөл болон гэнэтийн нөхцөл байдлын үед орон нутгийн иргэдэд ямар хариу арга хэмжээ авахыг төлөвлөнө.
- Гэрээт гүйцэтгэгч нь ажил үүрэг гүйцэтгэх хамгаалалтын бүх ажилтан, байгууллагуудыг зохих шалгалт, үзлэг хяналтад оруулна.

4.2.11. Хөдөлмөрийн харилцаа, ажлын нөхцөл

Хөдөлмөрийн журам, удирдлага болон барилгын кэмпиин талаарх мэдээлэл одоогоор тодорхойгүй байна. Гэсэн хэдий ч гэрээт гүйцэтгэгч нь Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль болон Олон улсын сайн туршлагад (ОУСТ) нийцүүлэн бүх байнгын болон түр ажилчидтай гэрээ байгуулна гэж тооцож байна. Төв Азид хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, албадан хөдөлмөрийн тохиолдлууд гарсан нь нийлүүлэлтийн гинжин хэлхээний хяналтгүйгээс үүдэлтэй юм. Барилгын ажилчдын кэмп нь ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлагуудад нийцсэн байх ёстой.

Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй ажиллагаатай холбогдуулан сонгосон Гэрээт гүйцэтгэгч нь төслийн ажлыг гүйцэтгэх хангалттай ажиллах хүч, тоног төхөөрөмжтэй байна гэж тооцож байна. Гэвч бүх барилгын ажлын талбайд тохиолддогчлон ажилчид ажлын байран дахь үйл ажиллагаатай холбоотойгоор хувийн аюулгүй байдлын нэмэлт эрсдэлд өртөх магадлал бий. Гэрээт гүйцэтгэгчээс аюул

ослыг арилгах удирдлагын зохион байгуулалт, журмуудыг боловсруулж арилгах боломжгүй бол ажиллах хүчний эрүүл мэнд, аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэлийг бууруулахыг шаардана.

Доорх бууруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдал, хөдөлмөрийн нөхцөлд үзүүлэх сөрөг нөлөө бага, Осол гарах тохиолдолд ноцтой үр дагавартай байх болно

Дараах бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- Хөдөлмөрийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, Хөдөлмөрийн гомдол шийдвэрлэх механизм бий болгох.
- Ажилчдын кэмпиог ЕСБХБ/ОУСК-н Удирдамж: Ажилчдын байр: журам ба стандартууд-ын дагуу байгуулна.
- Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.
- Гэрээт гүйцэтгэгч нь жендерийн тэгш байдлыг хангах боломжийг эрэлхийлэх хэрэгтэй.
- Гэрээт гүйцэтгэгч нь орон нутгийн ажиллах хүчийг бэлтгэн, сургалтанд хамруулна.
- Ажил, үүрэг даалгаварын тодорхой аюулын шинжилгээ, хяналтыг бүх үйл ажиллагаанд хэрэгжүүлнэ.
- Гэрээт гүйцэтгэгч нь Гэнэтийн нөхцөл байдалд бэлэн байх, хариу арга хэмжээ авах нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, түгээх

4.2.12. Соёлын өв

Газар шорооны ажилтай холбоотой төслийн аливаа ажлаас үүдэн өмнө тогтоосон болон тогтоогоогүй соёлын биет өвийн газрууд, археологийн эд зүйл болон тахилгат газрууд эвдрэх, бүрмөсөн эсхүл хязгаарлагдмал байдлаар тахилгат газруудад нэвтрэх боломжгүй байдал үүсч болно.

Төслийн ажил/төлөвлөгөөт түр ажлын талбайн нөлөөлөлд өртөж болзошгүй цаг үе нь тодорхойгүй нэгэн булшыг төслийн талбай дотор тогтоосон. ЦДАШ-ын маршрутын төвийн шугамнаас 3-4 км-ийн цаана 5 орон нутгийн хамгаалалттай газар байх ба эдгээрийг төслийн нөлөөлөлд өртөхгүй гэж үзэж байна. Гэвч энэ нь барилгын ажлын тээвэрлэлт хийх замын байршил болон бусад түр газар эзэмших шаардлага зэргээс хамаарах бөгөөд дээрх газруудаас аль болох хол байлгах шаардлагатай.

Тогтоогдсон болон тогтоогдоогүй соёлын биет өвийн болзошгүй хохирол нь барилгын явцад орон нутгийн бус ажилчид ирсэнээр үүсч болно.

Төслийн хүрээнд соёлын биет бус өв нь барилга угсралтын үеэр орон нутгийн бус ажиллах хүч орон нутагт шилжин ирсэнээс үүдэлтэй уламжлалт амьдралын хэв маягт өөрчлөлт орох байдлаар нөлөөлөлд өртөж болзошгүй ба ажилчид, орон нутгийн иргэд, ялангуяа малчдын хооронд зөрчилдөөн үүсгэж болзошгүй.

Цаашдын судалгаа болон Тохиолдлын Олдворын журмыг хэрэгжүүлэх замаар Тогтоогдсон болон тогтоогдоогүй соёлын биет болон биет бус өв, биет бус соёлын өвд үзүүлэх нөлөөөл бага зэрэг сөрөг байна.

Дараах бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- БОННБУ-ны үеэр тодорхойлогдсон булш, бунханг хянаж судлах, барилгын ажил эхлэхээс өмнө археологи, палеонтологийн судалгаа хийх мэргэжлийн байгууллагыг ажиллуулна. Тодорхойлогдсон талбай дээр мэргэжлийн байгууллагаас санал болгосон арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- Соёлын өвийн Тохиолдлын Олдворын журмыг боловсруулах, бүртгэл, тайлан боловсруулж хэрэгжүүлэх.
- Хэрэв тохиолдлын олдвор олдвол барилгын ажлыг даруй зогсоож сумын засаг дарга, цагдаагийн газар болон зохих байгууллагуудад мэдэгдэн мэргэжилтнүүдээр олдворыг тогтоолгоно.
- Барилгын ажилчдад соёлын өвийг хэрхэн хамгаалах талаар зөвлөгөө өгөх, ёс зүйн дүрэм боловсруулах.
- Гэрээт гүйцэтгэгч нь барилга угсралтын ажлын үеэр хамгаалах шаардлагатай аливаа газрыг тойруулан хашаа барьж, шаардлагатай үед орон нутгийнхныг оруулна.
- Гэрээт гүйцэтгэгч нь соёлын өв хулгайлагдах, гэмтээхээс урьдчилан сэргийлэх үүднээс мэдэгдэж буй соёлын өвийн талаарх мэдээллийг мэргэжилтний зөвлөмжгүйгээр нийтэлж зарлахгүй байх.

4.3. Ашиглалтын үе шат

4.3.1. Газар нутгийн биологийн олон янз байдал, ургамал, амьтан

Ашиглалтын явцад том хөхтөн амьтдад үзүүлэх болзошгүй нөлөөлөл нь ЦДАШ-н коридороос дайжих юм. Зэрлэг амьтад цахилгааны шугамын дагуу баригдах шинэ дэд бүтцийн үйл ажиллагаа, цахилгааны

шугамаас үүсэх дуу чимээнээс шалтгаалж цахилгааны шугамын коридороор гарахаас зайлсхийх ч тодорхой хугацааны дараа дасах магадлалтай. Төслийн газар нутаг нь тал бүрээсээ тээврийн хөдөлгөөн нэвтрэх боломжтой харьцангуй тэгш тал байдаг учраас зам засварын ажил гүйцэтгэхэд орчны тэнцвэртэй байдал алдагдах нөлөөлөл бий болно.

Төслийн үйл ажиллагааны нөлөөнөөс шувуудад учрах нөлөөлөл нь өндөр хүчдэлийн шугамын цахилгаанд цохиулах, мөргөлдөх эрсдлээр хязгаарлагдаж байна.

Төслийн талбай дахь ЦДАШ-тай хамгийн их мөргөлддөг, мөргөлдөх эрсдэлтэй шувууны зүйлүүд нь ховордсон зүйл болох Монгол ногтруу (*Syrrhaptes paradoxus*); Нийгэм эдийн засгийн үнэ цэнэтэй зүйл болох Дорнын хиазат (*Charadrius veredus*) юм. Үүнийг Намрын шувууны судалгааны дараа баталгаажуулна. ЦДАШ-ын утаснуудад Харагдах байдлыг сайжруулах багаж буюу дүрсээр Шувуу үргэгч суурилуулж шувуудыг цахилгааны утас мөргөх эрсдлийг бууруулах боломжтой.

Доорх бууруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр ашиглалтын үе шатанд бий болох сөрөг нөлөө дундаас бага зэрэг болох боломжтой.

Дараах бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- Дорнын хиазат, Монгол ногтруу, Идлэг шонхор, Тарважи бүргэд, Хажилгат ханчир, Хошуу галууг хамгаалах шувууны судалгаагаар тодорхойлсон газруудад суурилуулах үйлдвэрлэгчийн өгсөн зөвлөмжийн дагуу дамжуулагч болон газардуулгын кабельд суурилуулах шувууны нислэгийн чиг өөрчлөгч, шувуу үргэгчийн шилдэг зураг төслийг гаргах.

Хяналт шинжилгээний шаардлагууд:

- Цахилгаан дамжуулах шугамын дагуу шувууны сэг зэмд тогтмол хяналт шинжилгээ явуулна. Шаардлагатай тохиолдолд шувууны үхэл хорогдлын түвшин өндөр байгаа газарт шувуу үргэгч байрлуулах газрыг нэмэх, бусад менежментийн нэмэлт арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

4.3.2. Дуу шуугиан, доргио чичиргээ

ЦДАШ-н дагуух болзошгүй дуу шуугианы нөлөөлөл нь титмийн нөлөөнөөс үүдэлтэй байж болзошгүй. (Орон нутгийн цахилгаан орон нь эрчим хүчний нөлөө болон дамжуулагч утасны цахилгаан цэнэгийн нөлөөгөөр цахилгаанжиж болзошгүй. Эргэн тойрны агаарын молекул нь ионжиж, орчны цахилгаан цэнэгийг идэвхижүүлнэ) Мөн тодорхой өнцгөөс хамааран өндөр хурдтай салхитай үед салхины чимээ ихээр үүсдэг. ЦДАШ-ын дагуу нөлөөлөлд өртөж болзошгүй мэдрэмтгий хүлээн авагчид нь малчин өрхүүд, тэдний мал сүрэг болон ашиглалтын үе шатны ажиллах хүч байх хэдий ч ЦДАШ-ын зураг төслийг боловсруулахдаа титмийн нөлөөг бууруулах, дуу шуугианаас сэргийлэх арга техникийг нэвтрүүлснээр титмийн нөлөөгөөр үүсэх болон салхины шуугиан нь төслийн үйл ажиллагаанд төдийлөн нөлөөлөхгүй гэж үзэж байна.

Доорх бууруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр ашиглалтын явцад үзүүлэх нийт сөрөг нөлөөллийн түвшин бага зэрэг байна.

Дараах бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- ЦДАШ болон дэд станцын зураг төслийг олон улсын сайн туршлагад нийцүүлэн төлөвлөх бөгөөд тоног төхөөрөмж нь үндэсний болон ДЭМБ-ын дагаж мөрдөх дуу чимээний стандартын шаардлагыг хангасан байх шаардлагатай.
- Хэрэв дэд станцуудын дуу шуугиантай холбоотой гомдол ирвэл трансформаторуудаас үүсэх дуу шуугианы түвшинг хянаж, шалгах шаардлагатай.
- Тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангахын тулд засвар үйлчилгээг байнга хийнэ.

4.3.3. Хог хаягдлын менежмент

Ашиглалт, засвар үйлчилгээний үе шатанд явагдах тогтмол үйл ажиллагаа одоогоор мэдэгдэхгүй байгаа тул үүсэх хог хаягдлын хэмжээг тодорхойлох боломжгүй байна. Ашиглалтын шатанд таамаглаж буй хатуу хог хаягдал нь Хамгаалалтын зурвасын тариаланг цэвэрлэх үед гарах ургамлын хаягдал, баглаа боодлын материал, эвдэрсэн кабель, дамжуулагч, тусгаарлагч зэргээс үүсэх магадлалтай. Түүнээс гадна тос тосолгоо, шатахуун, будаг зэрэг шингэн бодис санаандгүй асгарсанаас үүсэх хаягдал бий болж болзошгүй. Дэд станцын ашиглалтын шатанд трансформаторын тос, талбайн засвар үйлчилгээнээс гарсан хаягдал, хог хаягдал, цаас, хоол хүнсний зүйл зэрэг ахуйн хаягдал үүсэх ба тос тосолгоо, шатахуун, будаг зэрэг шингэн бодис санаандгүй асгарсанаас үүсэх хаягдал мөн үүсч болзошгүй.

Хаягдлыг хадгалах, зайлуулах, цуглуулах зэрэг хаягдлыг зохицуулах үйл ажиллагаа доголдсоны улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд учрах хэд хэдэн эрслүүд бий. Хаягдлын зохицуулалтыг буруу явуулах, хадгалах нь бохирдол үүсгэх, хаягдал салхинд хийсэх, агаар, хөрс, усны нөөцийг бохирдуулан улмаар хүний эрүүл мэндэд (ажилчид болон орон нутгийн иргэд), ан амьтдад (мал сүрэг орно) шууд болон шууд бус нөлөө үзүүлэх сөрөг үр дагавар бий болгох эрсдэлтэй.

Төслийн бүсэд зөвшөөрөлтэй хаягдлын цэг, аюултай хог хаягдлын менежментийн байгууламж байхгүй тул хог хаягдлыг орон нутгийн эрх бүхий байгууллагаас батлагдсан, тогтоосон газарт зайлуулах шаардлагатай.

Доорх бууруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр ашиглалтын явцад үзүүлэх сөрөг нөлөө бага байх болно.

Дараах бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

- Ашиглалтын шатанд Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.
- Аюултай хог хаягдлыг зайлуулах ажлыг тусгай зөвшөөрөлтэй компани гүйцэтгэнэ.

4.3.4. Газар ашиглах

Төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд ЦДАШ-ын цамхагийн доор; Хамгаалалтын зурвасын дамжин өнгөрөх замд уул уурхайн хайгуулын дөрвөн лицензит талбай өртөх ба лиценз эзэмшигчид уг агаарын шугамыг лицензит талбайгаар дайран өнгөрөхийг зөвшөөрсөн. Эдгээрийн газар ашиглалтын лицензыг бүхэлд нь өөрчлөхөд хүрч болох талтай. (Ашиглалтын уурхайд нөлөөлөхгүй). Мөн ЦДАШ-ын маршрут дайран өнгөрөх тав дахь талбайн лицензийн хугацааг сунгаагүй бөгөөд газрыг Төслийн хүрээнд ашиглах талаар холбогдох байгууллагууд тохиролцсон. Төслийн үйл ажиллагаанд орон нутгийн хамгаалалттай бүс болох Тогоотлийн хонхор болон Борнурууны газар өртөх хэдий ч зөвхөн дамжуулах шугамын багана суурилуулах учраас газар ашиглалтад төдийлөн нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

Хамгаалалтын зурвасын бүсэд ямар нэгэн байнгын ажиллагаатай байгууламж барьж байгуулахгүй тул тухайн бүсэд мал бэлчээрлүүлэхийг зөвшөөрнө. Тиймээс газар болон бэлчээр ашиглалтад ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Хамгаалалтын зурвасыг цэвэрлэх үеэр мал оруулахыг түр хугацаагаар хориглож болох талтай.

Оролцогч талуудтай хийх хэлэлцүүлгийн үеэр төслийн бүс дэхь талбай нь малын бэлчээр, ус хангамж, бэлчээрийн даац, хүрэлцээ хомс, бэлчээрийг хуваан эзэмших талаар учир дутагдалтай байгааг болон малчдын зардлаар бусад хүнд үйлдвэрлэл, уул уурхайг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх бүсийн хэмжээний цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэр шаардлагатайг олж илрүүлсний дагуу төслийн үйл ажиллагаа хэрэгжих болсон. Өөдрөг, эерэг талаас нь авч үзэхэд төсөл нь цахилгаан дамжуулах найдвартай эх үүсвэрийг бий болгох нь төслийн бүс дэхь сум орон нутгийн тухайлбал Чойр, Сайншанд сумын цаашдын хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулж, хөгжлийг хурдасгах боломжийг бүрдүүлж байгаа хэрэг юм.

Доорх бууруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр ашиглалтын явцад газар ашиглалттай холбоотой үл ялиг сөрөг нөлөөлөл дунд зэргийн эерэг нөлөө болгох боломж бүрдэнэ.

4.3.5. Эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт, амжиргаа

Ашиглалтын шатанд Төсөл нь улс, бүс нутаг, орон нутгийн эдийн засагт шууд эерэг нөлөө үзүүлнэ. Сайжруулсан цахилгаан дамжуулах үйлчилгээ нь Төслийн бүсэд шинэ бизнесийг хөгжүүлэхэд түлхэц өгч, орон нутгийн эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх ба бүс нутгийн болон улсын төсвийн орлого нэмэгдүүлэх боломж бүрдүүлэх юм.

Барилгын үе шат дууссаны дараа ажил эрхлэх боломж харьцангуй хязгаарлагдмал байх хэдий ч ашиглалт, засвар үйлчилгээ, шинэ дэд станцын ажилд ажилтан авах шаардлагатай болно. Одоогийн нөхцөлд нэмэлт ажиллах хүч шаардагдах эсэхийг тодорхой хэлэх боломжгүй байна.

Цахилгаан дамжуулах системийг сайжруулснаар эрчим хүчний хангамж сайжирч орон нутгийн эдийн засагт хувь нэмэр оруулах ба ингэснээр амьжиргаанд үзүүлэх нөлөөлөл голчлон эерэг байх ба малчдад үлдэх сөрөг нөлөөлөл байхгүй гэж тооцоолсон.

Доорх бууруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр эдийн засаг, амьжиргаанд үзүүлэх нийт нөлөөллийг дунд зэргийн эерэг гэж үзнэ.

Дараах бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

- ЦДАШ-ын ашиглалт, засвар үйлчилгээнд орон нутгийн ханган нийлүүлэгч, гэрээт байгууллагыг ажиллуулах.
- Боломжит ажлын байранд орон нутгийн иргэдийг ажилд авах.

- Орон нутгийн хангамжийг авах, орон нутгийн туслан гүйцэтгэгчийг ашиглалт, засвар үйлчилгээнд ажиллуулах.

4.3.6. Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хамгаалал

Ашиглалтын шатанд төслийн үйл ажиллагаанаас иргэд, олон нийтэд учирч болзошгүй эрсдлүүдэд: Өндөр хүчдэлд цохиулах, өндөр хүчдлийн шон унасаны улмаас гал гарах, аянга цахилгаанд цохигдох, механик гэмтлийн улмаас цахилгаан дамжуулагч унах, цахилгаан дамжуулах цамхаг, шон унах зэрэг багтана. Дэд станцын бүсэд түлш, тос, тосолгооны материал, галд шатамхай бүтээгдэхүүнийг хадгалах, ашигласны улмаас гал түймэр гарч болзошгүй.

ЦДАШ-ын инженерийн зураг төсөлд олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлын зохих арга хэмжээг тусгана. ЦДАШ-ын барилга байгууламж бүр дээр газардуулгын кабель ашиглан газардуулгыг сайтар хийсэн байна. Анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ, авирахаас сэргийлсэн хаалт, өргөстэй төмөр утас бүхий саад, хашаа зэргийг сайтар байрлуулна. Дэд станц нь зөвшөөрөлгүй буюу гадны хүн орохоос сэргийлсэн тэмдэг тэмдэглэгээ бүхий хамгаалалтын хашаагаар хүрээлэгдсэн байна. Ашиглалт, засвар үйлчилгээний ажлын үеэр ЦДАШ ын ойролцоо амьдрах малчин өрхүүд дуу шуугиан, доргио чичиргээ, тоосжилтийн нөлөөнд өртөж болзошгүй хэдий ч нөлөөлөл бага зэрэг байна гэж үзэж байна.

Цахилгааны шугам нь цахилгаан давтамж, цахилгаан соронзон оронг үүсгэх эх үүсвэр гэж үздэг бөгөөд энэ нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй. Тиймээс ЦДАШ ын зураг төсөлд цахилгаан соронзон орны зөвшөөрөгдөх хязгаарыг ажлын байрны эрүүл мэнд, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн талаархи удирдамжид нийцүүлэн тодорхойлох бөгөөд цахилгаан соронзон орны аюулын талаар иргэд, олон нийтэд тайлбарлаж, зохих мэдлэг олгоход анхаарах хэрэгтэй.

Доорх бууруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр иргэд, олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх сөрөг нөлөөлөл бага зэргээс үл ялиг болж буурах боломжтой.

Дараах бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

- ЦДАШ-ын зураг төсөлд цахилгаан соронзон орны зөвшөөрөгдөх хязгаарыг ажлын байрны эрүүл мэнд, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн талаархи удирдамжид нийцүүлэн тодорхойлох.
- Шаардлагатай тохиолдолд (эсхүл гомдол гарсан үед) Зээлдэгч нь өртөлтийн түвшинг тодорхойлж, бууруулах арга хэмжээг авна. Шаардлагатай тохиолдолд тусгай металын орц бүхий хамгаалалт босгох, зайг өөрчлөх, баганы хоорондын зай болон тохиргоог орон нутгийн онцлогт тохируулан өөрчлөх гэх мэт нэмэлт арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдлийг бууруулахын тулд зураг төслийг зөв төлөвлөж, засвар үйлчилгээг тогтмол хангаж, газардуулгыг сайтар хийх, анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байрлуулах, өргөст тороор хашаалах, авирахаас сэргийлсэн саад хийх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
- Өндөр хүчдлийн шугамтай холбоотой болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүргэх, чадавхийг бэхжүүлэх талаар орон нутгийн иргэдийн дунд компани ажлууд зохион байгуулах.
- Дэд станцыг зөвшөөрөлгүй гадны хүн нэвтрэхээс сэргийлж, хамгаалалтын бүс байгуулах.
- Дэд станцуудад гал унтраах зохих байгууламжийг ажиллуулна. Хамгаалалтын зурваст гал гаргахыг хориглоно.

4.3.7. Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдал, Хөдөлмөрийн нөхцөл

ЦДАШ-ын ашиглалт, засвар үйлчилгээний ажлуудад ЦДҮС болон завсар үйлчилгээний компаниудтай гэрээ байгуулсаны үндсэн дээр ажилтнуудыг авч ажиллуулах ба төслийн өнөөгийн шатанд ашиглалт, засвар үйлчилгээнд шаардлагатай ажиллах хүчний тоог гаргах боломжгүй байна. ЦДҮС болон ашиглалт, засвар үйлчилгээний гэрээт гүйцэтгэгчид нь Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийг дагаж мөрдөх бөгөөд байнгын болон түр хугацааны ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллах үүргийг хүлээнэ.

Ашиглалтын шатанд Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой болзошгүй эрсдлүүдэд: Өндөр хүчдэлд цохиулах, өндөр хүчдлийн шон унах, аянга цахилгааны улмаас гал гарах, цахилгаан дамжуулах цамхаг, шон унах, өндрөөс унах болон дэд станцад гал гарах зэрэг багтана.

Дээрх иргэд, олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд учирч болзошгүй нөлөөллийг бууруулахын тулд эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй зайд цахилгааны шонг байрлуулах, төв шугамаас 20 м зайд байхаар хоорондын зайг тохируулах, өдөрт 4 цагаас хэтрэхгүй хугацаанд ажилтнуудыг цахилгааны дамжуулах шугамын бүсэд ажиллуулах зэрэг судалгаанд үндэслэсэн зохих арга хэмжээг хэрэгжүүлнэ. Ашиглалтын болон засвар үйлчилгээний ажил нь төлөвлөгөөт хугацаанаас хэтэрч үргэлжилж магадгүй тул Зээлдэгч болон ЦДҮС нь ажилчид нөлөөлөлд өртөх, ялангуяа дэд станцын ажилтнуудад учирч болзошгүй эрсдэл, нөлөөллийг бууруулах арга хэмжээг зохих түвшинд хэрэгжүүлэх үүргийг хүлээх ба

ашиглалт, засвар үйлчилгээний үе шатанд учирч болзошгүй эрсдлээс сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж, үнэлгээ, хяналт шинжилгээ явуулах нь зүйтэй.

Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдал, хөдөлмөрийн нөхцөлд үзүүлэх болзошгүй эрсдэл бага байх бөгөөд ашиглалтын явцад үл ялигаас бага зэрэг эерэг нөлөө үзүүлэх боломжтой.

Дараах бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

- Ашиглалт, засвар үйлчилгээний менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. Үүнд Хөдөлмөрийн харилцаа, ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийг багтаана.
- Онцгой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.
- Хөдөлмөрийн гомдол шийдвэрлэх механизмыг боловсруулна.
- ЦДАШ ын зураг төсөлд цахилгаан соронзон орны зөвшөөрөгдөх хязгаарыг ажлын байрны өртөлтийн удирдамжид нийцүүлэн тодорхойлох. Зээлдэгч/ЦДҮС нь ажилчид нөлөөлөлд өртөх, ялангуяа дэд станцын ажилтнуудад учирч болзошгүй эрсдлээс сэргийлэх, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлж, үнэлгээ, хяналт шинжилгээ явуулах.

4.3.8. Дэд бүтэц

Цахилгаан дамжуулах шугамын индукцийн нөлөө харилцаа холбооны хэрэгслүүдэд; түүний дотор радио, телевиз, утасны шугам / гар утсанд нөлөөлж болзошгүй боловч санал болгож буй маршрутын ойролцоо харилцаа холбооны шугам байхгүй бөгөөд бусад харилцаа холбооны хэрэгслүүдэд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна. Цахилгааны шугамын радио, телевизд учруулах хөндлөнгийн түвшинг бууруулах байдлаар зураг төсөлд тусгах шаардлагатай.

Ашиглалтын явцад дамжуулах шугамын дагуу эргүүл хийх тоо нэмэгдэх, аливаа осол аваар гарч болзошгүй тул эмнэлгийн байгууламж, тусламж үйлчилгээний хэрэгцээ орон нутагт үүсэж болох юм. Хэдий тийм боловч ашиглалт, засвар үйлчилгээний төлөвлөгөө болон бэлэн байдлын төлөвлөгөөг талууд хамтран зөв зохистой хэрэгжүүлсэн тохиолдолд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах түвшин бага, учрах эрсдэл болон орон нутгийн үйлчилгээний ачаалал бага байх болно гэдгийг анхаарах нь зүйтэй.

4.4. Үлдэх нөлөөллийн үнэлгээ

Барилгын шатны үйл ажиллагаанд агаарт дэгдэх тоосжилт, хийн ялгарал, дуу шуугиан зэргээс хүн, ургамал, амьтны зүйлд үзүүлэх хосолсон нөлөөлөл тэдгээр нөлөөлөлд өртөгчид учрах дан ганц нөлөөллөөс харьцангуй их нөлөө үзүүлж байдаг. Барилгын талбайн ойр орчим амьдардаг малчин өрхүүдэд хийн ялгарал, тээврийн хөдөлгөөний эрчим, дуу шуугиан ихсэх, хог хаягдлын менежментийн хангалтгүй үйл ажиллагааны улмаас тав тух алдагдаж, сөрөг нөлөөлөлд учрах эрсдэлтэй. Мөн эдгээр талбайн зэргэлдээ байх ургамал, амьтны зүйлүүд дуу чимээ, тоосжилт, хог хаягдал, бохирдлын хосолсон нөлөөлөлд өртөж болзошгүй юм.

Ашиглалтын явцад хосолсон нөлөөлөл үзүүлэхгүй гэж таамаглаж байна. Илүү үр ашигтай, найдвартай цахилгаан дамжуулах сүлжээ бий болох нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, орон нутгийн хөгжлийг дэмжин хөгжүүлэх, орон нутагт ажил эрхлэх боломжийг бүрдүүлснээр эргээд орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах зэрэг олон хосолсон нөлөөлөл нь эдийн засагт эерэг хуримтлагдах нөлөөллийг үзүүлэх болно.

Барилгын үе шатанд Төслийн бүсэд явагдах томоохон төслийн үйл ажиллагаа төлөвлөгдсөн талаар мэдэгдээгүй байна. Гэхдээ цаашид төслийн бүсэд хэд хэдэн хөгжүүлэлтийн ажил хийгдэхээр байгаа бөгөөд эдгээр нь төслийн бүсийг хангаж байгаа эрчим хүчнээс зарим талаар хамааралтай. Хэдийгээр нэмэлт хөгжүүлэх ажлууд нь байгаль орчинд сөрөг хуримтлагдах нөлөө үзүүлж болзошгүй ба бэлчээрийн доройтол, улмаар уламжлалт амьжиргаа, түүнтэй холбоотой соёлын биет бус өв буурах болзошгүй ч ашиглалтын явцад Төслийн бүсэд хийгдэж буй бүтээн байгуулалтын хөгжилтэй холбоотой эерэг хуримтлагдах нөлөө бий болох бөгөөд энэ нь ажил эрхлэлт, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх эерэг үлдэх нөлөө үзүүлэх болно.

5. Оролцогч талуудын оролцоог хангах ба Гомдол шийдвэрлэх механизм

5.1. Оролцогч талуудын оролцоо

БОННБҮ-ийн тодруулгын багцын нэг хэсэг болох оролцогч талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ОТОХТ) боловсруулсан бөгөөд дараах зүйлийг багтаасан болно:

- Танилцуулга;
- Төслийн тодорхойлолт;
- Оролцогч талуудын оролцоо, мэдээллийг нээлттэй ил тод болгох хууль, эрх зүйн орчин;
- Оролцогч талуудыг тодорхойлох;
- Нэмэлт оролцоо;
- Ирээдүйн оролцогч талуудын оролцооны хөтөлбөр;
- Гомдол шийдвэрлэх механизм;
- Хяналт шинжилгээ, тайлагнах;
- Нөөц ба хариуцлага.

ОТОХТ нь Төслийн оролцогч талуудын оролцооны арга хэлбэр, тодорхойлсон гол оролцогч талууд болон санал хүсэлтийг хэрхэн өгөх, санал хүсэлт, тайлбарыг хэрхэн шийдвэрлэхийг тодорхойлно. The SEP defines the stakeholder engagement approach for the Project, the key identified stakeholders and how to provide feedback and how any feedback and comments are addressed. **Хэлэлцүүлэг, зөвлөгөөнд оролцох шаардлагатай аливаа оролцогч талууд ЦДҮС-тэй холбогдоно.**

Төслийн БОННБҮ-ний баг БОННБҮ-ийн тодруулгын багцад оруулах ажлын хоёр үе шатыг хэрэгжүүлсэн:

- Төслийн талаархи суурь мэдээлэл цуглуулах, тулгамдсан асуудлыг олж мэдэх, сонсох зорилгоор 2020 оны 4-р сарын 19-нөөс 23-ны хооронд хийх ажлын эхний үе шат. КОВИД-19 хязгаарлалт, мал төллөх үе аль аль нь ярилцлага хийх гол албан тушаалтнуудын тоог хязгаарлах нөлөө үзүүлсэн. Уулзалтад хоёр байршлаас нийт 22 албан тушаалтан оролцсон байна.
- Албан ёсны уулзалтууд, Гол оролцогч талтай хийх ганцаарчилсан ярилцлага, Малчин өрхийн судалгааг хамарсан 2020 оны 6-р сарын 8-аас 12-ны хооронд зохион байгуулсан хоёр дахь үе. Сүмбэр, Шивээговь, Даланжаргалан, Айраг, Сайншанд гэсэн таван суманд очиж ажилласан. Нийт 54 албан тушаалтан хамрагдсан бөгөөд 34 гол оролцогч талтай хийх ярилцлага, 22 өрхийн судалгааг явуулсан.

Ирээдүйн оролцогч талуудын оролцооны хөтөлбөр дараахь үе шатуудаас бүрдэнэ:

- БОННБҮ-ны Толилуулга;
- Барилгын өмнөх үе;
- Барилга;
- Ашиглалт, засвар үйлчилгээний үе шат.

Мэдээллийг ил тод болгох зорилго нь оролцогч талууд байгаль орчин, нийгмийн нөлөөллийн талаар ойлгож мэдэх, Төсөл эдгээр нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, / хянах талаар мэдээлэх боломжийг бүрдүүлэх; Төслийн багт аливаа санал хүсэлт, тулгамдсан асуудлын талаар мэдэгдэх зэрэг боломжийг бүрдүүлэх юм. Төслийн БОННБҮ-ийн тодруулгын багцыг англи, монгол хэлээр бэлтгэж, ЕСБХБ-ны вэбсайтад (www.ebrd.com) тавьж, ЕСБХБ-ын шаардлагын дагуу 120 хоногийн хугацаанд байрлуулна.

Эдгээр баримт бичгүүдийн цаасан хувийг Монгол улс, Улаанбаатар хот дахь ЕСБХБ болон Зээлдэгчийн оффисоос авах боломжтой. Түүнчлэн ТБХ, ГЧНШҮА, ОНОХТ-ийн хэвлэмэл хуулбарыг төслийн нөлөөлөлд өртсөн аймаг, сум, багийн нутгийн захиргааны байгууллагуудтай хуваалцаж, сонирхогч талуудаар хянуулна. Боломжтой бол гол захиргааны төлөөлөгчидтэй нүүр тулсан (одоогийн мөрдөж буй хүн хоорондын зайг баримтласан аюулгүй байдлын туршлагыг ашиглана) уулзалт зохион байгуулах; Хэрэв нүүр тулсан уулзалт зохион байгуулах боломжгүй гэж үзвэл утсаар эсхүл цахим хурал зохион байгуулан хуваалцах болно. Мэдээлэл түгээх бусад сувгуудад зарын самбар, фэйсбүүк хуудас орно.

5.2. Гомдол шийдвэрлэх механизм

Гомдол шийдвэрлэх механизмын талаар ОТОХТ-нд тусгасан. Энэхүү механизм нь оролцогч талуудад гомдол гаргах, санал гомдлыг бүртгэх болон ялангуяа төслийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн талаархи санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэхэд хялбар болгох үүднээс бүх оролцогч талуудад нээлттэй байна. Энэ нь Төсөлтэй холбоотой оролцогч талуудын санал хүсэлтийг цаг тухайд нь хүлээн авч, хариу өгөх боломжийг олгоно.

6. Байгаль орчин, нийгмийн менежмент

6.1. Төслийн менежмент, гүйцэтгэл

ЭХЯ нь Төслийн Зээлдэгч тал бөгөөд Төслийн барилгын үе шатны хэрэгжилтийг хянах Төсөл хэрэгжүүлэгч нэгжийг тус яаман дээр байгуулахаар төлөвлөж байна. ТХН дотор Байгаль Орчин, Нийгмийн Удирдлагын Тогтолцоог (БОНУТ) хариуцах этгээдийг томилно. Уг этгээд нь ТХН-ийн ажилтнууд болон шаардлагатай тохиолдолд Гэрээт гүйцэтгэгчийн ажилтнуудыг хангалттай хэмжээнд сургах ажлыг хариуцна.

Төслийн барилгын ажлыг гүйцэтгэх Барилгын ажлын гэрээт гүйцэтгэгч (эсхүл Гэрээт гүйцэтгэгчид)-г томилно. Барилгын ажлын гэрээт гүйцэтгэгчид Төслийн БОНУТ-нд заасан шаардлагад нийцэж буй эсэхэд хяналт тавьж, үзлэг шалгалт хийхээр төлөвлөж байна.

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь Барилгын ажлын гэрээт гүйцэтгэгчийн Төслийн БОНУТ-ны шаардлагыг хангаж буй эсэхэд тогтмол хяналт, шалгалт явуулна.

6.2. Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө

Төслийн Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө (БОНУАТ) ЕСБХБ-ын шаардлагад нийцүүлэн боловсруулсан. БОНУАТ-ний зорилго нь Төслийн үйл ажиллагаанаас үүдэх сөрөг нөлөөллийг хянах, хязгаарлах, бууруулах (болон эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх) зорилт, үйл ажиллагааны хуваарь, үүрэг хариуцлагыг нарийвчлан боловсруулж, Төслийн (ба Гэрээт гүйцэтгэгчийн) гүйцэтгэлийг хэмжиж болох үзүүлэлтүүдийг тогтооход оршино.

БОНУАТ нь Төслийн БОНМХШТ-г боловсруулах шаардлагыг тавьдаг. Барилга, ашиглалтын явцад Төслийн ажилтнууд болон Барилгын гэрээт гүйцэтгэгч нар БОНУАТ-д заасан шаардлагуудад нийцүүлж ажил үүргээ гүйцэтгэнэ. БОНУАТ-г Монгол Улсын зөвшөөрлийн шаардлага, хууль тогтоомж, ЕСБХБ-ийн БОННБҮ-ийн тодруулгын багц шаардлагыг ханган бэлтгэнэ.

6.3. БОНУТ болон Менежментийн төлөвлөгөө

Гэрээт гүйцэтгэгчийн удирдлагын тогтолцооны үйл ажиллагааг хангах Төслийн БОНУТ-г боловсруулна.

Төслийн БОНУТ нь дараах зүйлсийг хамрана:

- Бодлого, дүрэм журмууд;
- Төслийн Байгаль Орчин, Нийгмийн Менежмент, Хяналт шинжилгээний төлөвлөгөө (БОНМХШТ);
- Хууль эрх зүйн бичиг баримт, зөвшөөрлийн бүртгэл;
- Үүрэг хариуцлага, ажил үүргүүд;
- Төслийн хуваарь.

БОННБҮ-ний тайлангийн хүрээнд БОНМХШТ-г боловсруулсан. ТХН нь Барилгын ажлын гэрээт гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахын өмнө үүнийг цааш илүү нарийвчлан боловсруулж нэмэлт судалгаа, төслийн зураг төсөлд оруулсан шинэчлэлүүдийг тусгах ба энэ нь Төслийн БОНМХШТ болно. БОНМХШТ нь тендерийн баримт бичгүүдийн шаардлагыг бүрдүүлнэ.


Барилгын ажлын гэрээт гүйцэтгэгч нь БОНУТ-г дагаж мөрдөн илүү нарийвчилсан систем, төлөвлөгөөг боловсруулах замаар төслийн гүйцэтгэлийн барилга ажилтай холбогдох зүйлсийг авч үзнэ. Үүний дагуу Барилгын нарийвчилсан БОНМХШТ-г бэлтгэнэ.

6.4. Түр талбайд тавигдах шаардлагууд

Яг одоогийн байдлаар Барилгын ажлын гэрээт гүйцэтгэгчийн кэмп болон ажлын талбай, барилгын ажлын/нэвтрэх замууд зэрэг бусад түр газруудын байршлын талаарх мэдээлэл байхгүй байна. Иймд барилгын ажлын гэрээт гүйцэтгэгч нь байгаль орчин, нийгэмд хамгийн бага нөлөөлөх ажлын түр талбайнуудыг сонгох шаардлагатай ба ингэхдээ сайн дурын нүүлгэн шилжүүлэлтийг аль болох хийхгүй байх эсхүл хамгийн бага байлгах байдлыг бодолцон шаардлагатай тохиолдолд сөрөг нөлөөллийг бууруулах нэмэлт арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой газрыг эцсийн байдлаар сонгох шаардлагатай.

6.5. Талбайг хүлээлгэн өгөх

Барилгын ажлын дараа Барилгын ажлын гэрээт гүйцэтгэгчээс талбайг Зээлдэгчид хүлээлгэн өгөхийн өмнө гэрээт гүйцэтгэгч нь түр ажлын талбайн газруудыг нөхөн сэргээх, төслийн зурвас доторх бүх хаягдлуудыг Зээлдэгчийн шаардлагад нийцэх байдлаар зайлуулах шаардлагатай.



Кэти Пребль
Аткинз Лимитед
Вүүдкот Грөүв
Эйшли Рөүд
Эпсом
КЭЙТИ18 5БИ ДАБЛЮ

©Даблю Эс Аткинз Интернэйшнл